

ХАСБАНК ХХК

Санхүүгийн тайлан болон хараат
бус аудиторын тайлан

2014 оны 12 сарын 31

ХАСБАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2014 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН

АГУУЛГА

ХУУДАС

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

1

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

6

ХАСБАНК ХХК

БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ

АЛБАН ХАЯГ:

ХасБанкны Байр
Ерөнхий Сайд Амарын гудамж,
Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721,
Улаанбаатар 14200,
Монгол Улс

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Чулууны Ганболд
Магваны Болд
Дүгэрсүрэнгийн Бат-Очир
Нямтайширийн Цэлмүүн
Ричард Ранкен
Шүжи Ири
Сабина Журмэн
Майкл Мадден
Баатарын Батсайхан (2014/4/3-нд сонгогдсон)
Жэймс Стент (2014/4/3-нд сонгогдсон)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Дашнямын Ашидмаа

АУДИТОР:

Делоитт Онч Аудит ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХасБанк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Бид ХасБанк ХХК (цаашид “Банк” гэх) -ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материалагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол зохистой эсэх, санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрддэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Банкны 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Бусад

Банкны 2013 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланг өөр аудитын компани аудитласан ба тус аудитор нь 2014 оны 03 дугаар сарын 25-нд зөрчилгүй дүгнэлт гаргасан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.



Deloitte Onch Audit LLC
Делоитт Онч Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2015 оны 3 дугаар сарын 18

ХАСБАНК ХХК

**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2014 мян.төг	2013 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	238,455,847	181,022,347
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(141,046,690)	(100,332,244)
Хүүгийн цэвэр орлого		97,409,157	80,690,103
Хураамж ба шимтгэлийн орлого	6	7,690,980	5,799,626
Хураамж ба шимтгэлийн зардал	6	(1,019,381)	(782,369)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	6	6,671,599	5,017,257
Арилжааны цэвэр орлого	7	54,028	2,568,294
Үйл ажиллагааны бусад орлого - цэвэр	8	(7,832,121)	4,142,363
Үйл ажиллагааны нийт орлого		96,302,663	92,418,017
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	9	(29,887,298)	(9,706,640)
Үйл ажиллагааны цэвэр орлого		66,415,365	82,711,377
Үйл ажиллагааны зардал	10	(55,111,209)	(54,142,727)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	29	903,878	1,323,934
Татварын өмнөх ашиг		12,208,034	29,892,584
Орлогын татварын зардал	11	(572,326)	(5,520,275)
Тайлант жилийн ашиг		11,635,708	24,372,309
Бусад дэлгэрэнгүй орлого		—	—
Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох, нийт дэлгэрэнгүй орлого (татварын дараах)		11,635,708	24,372,309
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):			
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	12	571.68	1,197.44
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	12	571.68	1,197.44

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХАСБАНК ХХК**2014 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2014 мян.төг	2013 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	13	187,780,433	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад			
байршуулсан харилцах, хадгаламж	14	138,422,940	121,851,611
Урвуу репо хэлцэл	15	152,799,124	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	1,469,087	636,835
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад			
бэлэн	17	7,751,391	15,500,694
Санхүүгийн хөрөнгө оруулалт – дуусвар			
хугацаа хүртэл эзэмших	17	211,594,397	329,582,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	1,313,697,656	1,029,541,294
Бусад хөрөнгө	19	6,602,101	4,361,822
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	20	10,727,557	5,105,763
Үндсэн хөрөнгө	21	31,241,651	29,595,235
Биет бус хөрөнгө	22	8,407,675	5,666,416
Хойшлогдсон татварын хөрөнгө	23	2,321,415	1,035,981
НИЙТ ХӨРӨНГӨ		2,072,815,427	1,811,484,592
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын			
байршуулсан харилцах, хадгаламж	24	34,317,691	141,706,978
Репо хэлцэл	25	179,763,676	162,428,300
Харилцагчдын харилцах, хадгаламж	26	797,749,013	644,483,183
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	2,427,739	626,804
Зээлээр авсан санхүүжилт	27	803,560,458	664,368,204
Хоёрдогч өглөг	28	97,925,342	58,637,886
Хойшлогдсон нөхцөлт хандив	29	1,622,531	1,957,277
Бусад өр төлбөр	30	21,206,909	13,142,756
Орлогын татварын өглөг		401,316	1,928,160
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,938,974,675	1,689,279,548
ЭЗДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа	31	20,353,656	20,353,656
Хувьцааны урамшуулал		34,989,097	34,989,097
Бусад нөөц	32	10,531,368	10,531,368
Хуримтлагдсан ашиг		67,966,631	56,330,923
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		133,840,752	122,205,044
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		2,072,815,427	1,811,484,592

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

ХАСБАНК ХХК**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

	Энгийн хувьцаа мян.төг	Хувьцааны урамшуулал мян.төг	Бусад нөөц мян.төг	Хуримтлагд- сан ашиг мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
2013.01.01-ний өдрийн байдлаарх үлдэгдэл	20,353,656	34,989,097	10,531,368	31,958,614	97,832,735
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	24,372,309	24,372,309
2013.12.31-ний өдрийн байдлаарх үлдэгдэл	<u>20,353,656</u>	<u>34,989,097</u>	<u>10,531,368</u>	<u>56,330,923</u>	<u>122,205,044</u>
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	11,635,708	11,635,708
2014.12.31-ний өдрийн байдлаарх үлдэгдэл	<u>20,353,656</u>	<u>34,989,097</u>	<u>10,531,368</u>	<u>67,966,631</u>	<u>133,840,752</u>

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

ХАСБАНК ХХК

2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тодруулга	2014 мян.төг	2013 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	12,208,034	29,892,584
<i>Тохируулга:-</i>		
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	7 (139,774)	(381,046)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз (олз)	8 466	(21,382)
Биет бус хөрөнгө борлуулсны гарз (олз)	2,465	(4,517)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны олз	(61,029)	(9,819)
Валютын ханшийн хэрэгжээгүй гарз (олз)	8 8,201,037	(3,479,465)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал	9 29,776,497	9,681,496
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	9 110,801	25,144
Үндсэн хөрөнгийн элэгдэл	10 4,255,388	3,710,494
Биет бус хөрөнгийн хорогдол	10 986,182	816,248
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	10 246,878	69
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралт	10 418,496	31,314
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	29 (903,878)	(1,323,934)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	55,101,563	38,937,186
<i>Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:-</i>		
Монголбанкинд заавал байлгах нөөц	(21,083,765)	(24,441,404)
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	(76,379,494)	20,100,764
Урвуу репо хэлцэл	(122,807,869)	(26,493,194)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(263,877,843)	(357,110,494)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	(5,560,765)	(4,064,367)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	(832,252)	-
Бусад хөрөнгө	(2,671,785)	2,578,714
<i>Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:-</i>		
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	(110,205,781)	81,954,306
Репо хэлцэл	17,335,376	99,423,685
Харилцагчдын харилцах, хадгаламж	140,112,627	115,677,112
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	842,283	-
Бусад өр төлбөр	6,492,287	4,682,119
Үндсэн үйл ажиллагаанд (зарцуулсан) мөнгө	(383,535,418)	(48,755,574)
Орлогын татварын төлөлт	(3,384,604)	(4,978,793)
Үндсэн үйл ажиллагаанд (зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ	(386,920,022)	(53,734,367)

ХАСБАНК ХХК**2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

	Тодруулга	2014 мян.төг	2013 мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө оруулалт		(30,406,121)	(69,580,206)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого		60,912,000	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		357,851	253,190
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		641,980	6,600
Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(6,506,999)	(8,545,289)
Биет бус хөрөнгийн худалдан авалт		(4,371,886)	(1,986,179)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас орж ирсэн (зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ		20,626,825	(79,851,884)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт		652,212,407	501,497,800
Хоёрдогч өглөгөөрх санхүүжилтийн татан авалт		57,556,522	-
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт		(567,103,685)	(165,082,378)
Хоёрдогч өглөгийн эргэн төлөлт		(27,990,300)	-
Төлсөн ногдол ашиг	33	(1,204)	-
Хүлээн авсан хойшлогдсон нөхцөлт хандив	29	569,132	1,704,573
Санхүүгийн үйл ажиллагаанаас орж ирсэн мөнгө		115,242,872	338,119,995
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө		23,906,037	19,548,729
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) өсөлт		(251,050,325)	204,533,745
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		519,971,783	295,889,309
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34	292,827,495	519,971,783
Хүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Төлсөн хүү		140,530,774	96,244,403
Хүлээн авсан хүү		232,049,888	177,687,958

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.

1. Банкны талаарх мэдээлэл

Тус банкны үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 24 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны мөн чанарт томоохон өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг албан хаяг нь ХасБанкны байр, Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс.

Банкны толгой компани нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК юм. Толгой компанийн хувьцаа эзэмшигчид нь:

- ▶ Монголын Алт Корпораци (МАК) ХХК
- ▶ Олон Улсын Санхүүгийн Корпораци
- ▶ ОРИКС Корпораци
- ▶ Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
- ▶ Ронок Партнерс С.А.Р.Л
- ▶ Мерси Корпс
- ▶ Монголиа Файнаншл Сервисез ХХК
- ▶ Ард Санхүүгийн Нэгдэл ХХК
- ▶ Триодос Фэйр Шэйр Сан
- ▶ Нээлттэй Нийгэм Форум
- ▶ Эм Си Эс Холдинг ХХК
- ▶ Улаанбаатар Ротари Клуб
- ▶ Магваны Болд
- ▶ Чулууны Ганболд

Санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн шийдвэрээр батлан гаргасан.

2.1 Тайлан бэлтгэсэн суурь

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх “Санхүүгийн үүсмэл хэрэгсэл”, "Борлуулахад бэлэн" болон "Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа" хөрөнгө оруулалтыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр, мянганы орноор нарийвчилж тайлагнасан.

Мөрдсөн стандарт

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

2.1 Тайлан бэлтгэсэн суурь (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойшхи хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл хийх төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 37-д толилуулсан.

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг хооронд нь хаах хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулсанчлан орлого, зарлагыг дэлгэрэнгүй орлогын тайланд хооронд нь хааж тайлагнаж болохгүй.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба таамаглал тооцоолол

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөх дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Гол үнэлэмж болон таамаглал тооцооллуудыг дор үзүүлэв. Үүнд:

Тасралтгүй үйл ажиллагаа

Банкны удирдлага Банкны тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд Банк нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Цаашилбал удирдлага нь банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг тодорхойгүй байдал байхгүй гэж үзэж байна. Тиймээс, Банкны санхүүгийн тайлангуудыг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэсэн.

Барилгын элэгдэл

Барилгын доорхи газрын түрээсийн хугацаа 40 жилээс бага гэсэн хэдий ч барилгыг ашиглалтын хугацаа болох 40 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Монгол Улсын Газрын тухай хуульд зааснаар Банк нь газрын түрээсийн хугацааг сунгах хүсэлтийг гаргах эрхтэй ба тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд засгийн газрын эрх бүхий байгууллага түрээсийн хугацааг сунгадаг. Банкны удирдлага тэдгээр шаардлагуудыг хангаж байгаа ба түрээсийн нийт хугацааг 40 жил гэж тооцоолсон нь зохистой, бодитой гэж үзэж байна.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд (Үргэлжлэл)

Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал

Банк нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр томоохон дүнтэй зээл ба урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, үнэ цэнийн бууралтыг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

Гарсан нь бодитоор нотлогдож байгаа гэхдээ үр дагавар нь бодитоор нотлогдоогүй алдагдлуудын улмаас сан байгуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох үүднээс тусгай үнэлгээгээр үнэлж, үнэ цэнийн бууралтгүй гэж тодорхойлсон зээл урьдчилгаанууд ба дангаар том дүнтэй биш бүх зээл ба урьдчилгаануудыг нийлүүлж, эрсдлийн ойролцоо шинж чанараар нь багцлан, багцын үнэлгээг хийнэ. Багцын үнэлгээ нь тухайн багцын өгөгдлүүд (хугацаа хэтрэлтийн түвшин, зээлийн ашиглалт, зээлийн дүн ба барьцаа хөрөнгийн дүнгийн хоорондын харьцаа гэх мэт) эрсдлийн төвлөрөл, эдийн засгийн өгөгдлүүд (ажилгүйдлийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнийн индексүүд гэх мэт)-ийг авч үздэг.

Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 9 ба 18-д толилуулсан болно.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Мөн Банк нь бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байгаа, борлуулахад бэлэн өмчийн хөрөнгө оруулалтууд дээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүртгэдэг. “Их хэмжээ”, “Урт хугацаа” гэдгийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Энэ үнэлэмжийг хийхдээ Банк нь хувьцааны үнийн өөрчлөлтийн түүх, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө ямар хугацаанд, ямар хэмжээгээр доогуур байсан зэрэг олон хүчин зүйлийг үнэлж үзнэ. Өмнө нь данснаас хассан байсан дүнгийн үнэ цэнэ дараа үед эргэж сэргэвэл хасагдуулгын дансны кредитэд бүртгэнэ. Хасагдуулгын дансны дансны үнэд гарсан өөрчлөлтийг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө

Алдагдлыг ашиглах боломжтой татвар ногдох ашиг олох магадлал байгаа үед татварын алдагдал дээр хойшлуулсан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд олох татвар ногдох ашгийн хугацаа, хэмжээ ба ирээдүйн татвар төлөвлөлтийн стратеги зэрэг дээр үндэслэн хойшлогдсон татварын хөрөнгийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрээс олж авах боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг ашиглах боломжтой зах зээлийн өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй байгаа тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Үнэлэмжинд төлбөрийн чадвар, урт хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хувирамтгай байдал, хөнгөлөлтийн түвшин, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өгөгдмөл хувь хэмжээний талаарх төсөөлөл гэх мэт загварын орцуудыг авч үзэх ажил багтана. Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэлгээний талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 35-т толилуулсан болно.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд

2014 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон доорхи шинэ болон шинэчлэгдсэн СТОУС-уудаас бусад Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхээс өөрчлөгдөөгүй байна.

Шинэ болон шинэчлэгдсэн стандартууд болон тайлбарууд

- | | |
|--|--|
| • СТОУС 10-ын өөрчлөлтүүд | <i>Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан – Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж</i> |
| • СТОУС 12-ын өөрчлөлтүүд | <i>Бусад аж ахуйн нэгж дэх хувь эзэмшлийн тодруулга – Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж</i> |
| • НББОУС 27-ийн өөрчлөлтүүд | <i>Тусдаа Санхүүгийн Тайлан – Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж</i> |
| • НББОУС 32-ын өөрчлөлтүүд | <i>Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга – Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнах</i> |
| • НББОУС 36-ийн өөрчлөлтүүд | <i>Хөрөнгийн үнэ цэнийн бууралт – Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дүнгийн тодруулга</i> |
| • НББОУС 39-ийн өөрчлөлтүүд | <i>Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт – Үүсмэл хэрэгслийн шинэчлэлт ба Хейджийн бүртгэлийг үргэлжлүүлэх нь</i> |
| • СТОУТХ 21 | <i>Төлбөр</i> |
| • Жилийн сайжруулалтууд (2010-2012 мөчлөг) | <i>2013 оны 12 сард гарсан хэд хэдэн СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд</i> |
| • Жилийн сайжруулалтууд (2012-2014 мөчлөг) | <i>2013 оны 12 сард гарсан хэд хэдэн СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд</i> |

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Шинэ болон шинэчлэгдсэн стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт нь Банкны санхүүгийн байдал болон гүйцэтгэлд томоохон нөлөө үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөнө.

- СТОУС 10 болон НББОУС 28, *СТОУС 10 болон НББОУС 28-ын өөрчлөлтүүд Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт болон хандив*¹
- СТОУС 11, *СТОУС 11-ийн өөрчлөлтүүд Хамтарсан үйл ажиллагааны хувь оролцоог олж эзэмших үеийн нягтлан бодох бүртгэл*¹
- СТОУС 14, *СТОУС 14-ийн өөрчлөлтүүд Зохицуулалтаар Хойшлуулах Дансад*¹
- НББОУС 16 болон НББОУС 38, *НББОУС 16 болон НББОУС 38-ын өөрчлөлтүүд Элэгдэл ба хорогдлын зохистой аргачлал*¹
- НББОУС 16 болон НББОУС 41, *НББОУС 16 болон НББОУС 41-ийн өөрчлөлтүүд Хөдөө аж ахуй: Үр өгөөжтэй ургамал*¹
- СТОУС 27, *СТОУС 27-ийн өөрчлөлтүүд Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга*¹
- СТОУС 9, *СТОУС 9-ийн өөрчлөлтүүд Санхүүгийн Хэрэглүүр*³
- СТОУС 15, *СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого*²

Тайлант үед хүчин төгөлдөр мөрдөгдөх СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд болон шинэ Тайлбарууд

Тайлант жилд, Банк нь 2014 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НББОУСЗ')-өөс батлан гаргасан шинэ болон шинэчлэгдсэн СТОУС-уудыг мөрдөж эхэлсэн

¹ 2016 оны 1-р сарын 1- ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

² 2017 оны 1-р сарын 1- ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

³ 2018 оны 1-р сарын 1- ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 27-ийн өөрчлөлтүүд *Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж-д орсон өөрчлөлт*

СТОУС 10-ийн өөрчлөлтөөр хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж нь охин компаниудыг нэгтгэхээс чөлөөлөгдөх нөхцлийг хангасан тохиолдолд хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж нь санхүүгийн тайландаа охин Компаниуд дахь өөрийн хөрөнгө оруулалтыг ашиг эсвэл алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг.

Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж болохын тулд тодорхой шалгууруудыг хангасан байх ёстой:

- Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор нэг ба түүнээс дээш хөрөнгө оруулагчаас бүрдсэн сан байгуулах
- Хөрөнгө оруулалтын сан нь бизнесийн зорилгоор үнийн өсөлттэй болон хөрөнгө оруулалтын ашиг хүртэх эсвэл хоёулангаас нь ашиг олох зорилготой байх үүргийг хөрөнгө оруулагчдад хүлээх
- Бүх хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн сууриар бодитойгоор хэмжиж, үнэлэх

СТОУС 12 болон НББОУС 27-ын өөрчлөлтөөр хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн шинэ тодруулгын шаардлагуудыг танилцуулсан.

Банк нь хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж биш учраас (2014 оны 1-р сарын 1-нээс хэрэгжсэн СТОУС 10 заасны дагуу шалгууруудыг үнэлсэнийн үр дүнд) Банкны санхүүгийн тайлан болон тодруулгуудад уг өөрчлөлт нь нөлөө үзүүлэхгүй гэж Банк үзэж байна.

НББОУС 32-ын өөрчлөлтүүд *Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнах*

НББОУС 32-ын өөрчлөлтүүд *Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнах*: санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрт цэвэр дүнгээр тайлагнах шаардлагуудыг тодорхой болгосон. Тухайлбал, “цэвэр дүнгээр нь хүлээн зөвшөөрч болохуйц хууль ёсны эрх үүссэн” мөн “цэвэр дүнгээр нь төлж барагдуулах зорилготой эсвэл нэгэн зэрэг хөрөнгө бүртгэж, өр төлөх” тодорхойлолтыг тодорхой болгосон.

Өөрчлөлтүүдийг буцаах горимоор хэрэгжүүлсэн. Энэхүү өөрчлөлтүүдийн хэрэгжилт нь Банкны санхүүгийн тайлан болон тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

НББОУС 36-ийн өөрчлөлтүүд *Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дүнгийн тодруулга*

Уг шинэчлэгдсэн НББОУС 36 *Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дүнгийн тодруулга*-ын өөрчлөлтөөр холбогдох мөнгө үүсгэгч нэгжид үнэ цэнийн бууралт гараагүй эсвэл үнийн цэнийн бууралтын буцаалт гараагүй үед гүүдвил болон тодорхойгүй ашиглах хугацаатай бусад биет бус хөрөнгийн хуваарилагдсан мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг тодруулах шаардлагыг хассан. Мөн бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжүүдийн нөхөн төлөгдөх дүн нь данснаас хасахад гарах өртгөөс доогуур байх бол нэмэлт тодруулгын шаардлагуудыг энэхүү өөрчлөлтөд танилцуулсан. Эдгээр нэмэлт тодруулгад бодит үнэ цэнийн шатлал, гол тооцооллууд болон СТОУС 13 *Бодит Үнэ Цэнийн Хэмжилт*-ийн шаардлагын дагуу үнэлэх аргачлалууд орсон.

Энэхүү өөрчлөлтүүдийн хэрэгжилт нь Банкны санхүүгийн тайлангийн тодруулгад материаллаг нөлөө үзүүлээгүй.

НББОУС 39-ийн өөрчлөлтүүд *Үүсмэл хэрэгслийн шинэчлэлт ба Хейджийн бүртгэлийг үргэлжлүүлэх нь*

НББОУС 39-ийн өөрчлөлт *Үүсмэл хэрэгслийн шинэчлэлт ба Хейджийн бүртгэлийг үргэлжлүүлэх нь*: хейджийн хэрэглүүр болж буй үүсмэл хэрэгсэл нь тодорхой нөхцлүүдийн дагуу шинэчлэгдэх үед хейджийн бүртгэлийг зогсоох шаардлагаас татгалзсан. Өөрчлөлтүүд нь мөн шинэчлэгдэж байгаа хейджийн хэрэглүүр болж буй үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэд гарсан аливаа өөрчлөлт нь хейджийн үр дүнгийн хэмжилтэнд орох шаардлагатай гэдгийг тодорхой болгосон.

Банкинд шинэчлэлтэнд орж буй ямар нэгэн үүсмэл хэрэгсэл байхгүй учраас, энэхүү өөрчлөлтүүдийн хэрэгжилт нь Банкны санхүүгийн тайлан болон тодруулгуудад нөлөө үзүүлэхгүй гэж Банк үзэж байна.

СТОУТХ 21 *Төлбөр*

СТОУСТХ 21 Төлбөр нь засгийн газарт төлөх төлбөрийг хэзээ өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх асуудлуудыг авч үздэг. Уг тайлбарт дурьдснаар төлбөр төлөх үүрэг үүсэх явдал нь холбогдох хууль тогтоомжид заасан үйл явдал болохыг зааж өгсөн. Уг тайлбар нь мөн төлбөрийн өөр өөр төрлүүдийг хэрхэн бүртгэх зааварчилгааг өгсөн. Ялангуяа эдийн засгийн үүрэг болон санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэсэн нь ирээдүйн үйл ажиллагаанаас үүсэх төлбөрийг одоо төлөх үүргийг бий болгодоггүй.

Уг тайлбар нь Банкны санхүүгийн тайлан болон тодруулгуудад нөлөө үзүүлэхгүй гэж Банк үзэж байна.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Банк нь дараах батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй шинэ болон шинэчлэгдсэн СТОУС-уудыг хэрэгжүүлээгүй байгаа болно:

СТОУС 9	Санхүүгийн Хэрэглүүр ⁵
СТОУС 15	Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого ⁴
СТОУС 22-ийн өөрчлөлтүүд	Хамтарсан үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмших үеийн нягтлан бодох бүртгэл ³
НББОУС 16 болон НББОУС 38-ын өөрчлөлтүүд	Элэгдэл ба хорогдлын зохистой аргачлал ³
НББОУС 16 болон НББОУС 41-ийн өөрчлөлтүүд	Хөдөө аж ахуй: Үр өгөөжтэй ургамал ³
НББОУС 19-ийн өөрчлөлтүүд	Тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөө: Ажилчдын хувь нэмэр ¹
СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд	СТОУС-ын 2010-2012-ын мөчлөгт хийгдсэн жил бүрийн сайжруулалтууд ²
СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд	СТОУС-ын 2011-2013-ын мөчлөгт хийгдсэн жил бүрийн сайжруулалтууд ¹

¹ 2014 оны 7-р сарын 1-нээр эхэлсэн эсвэл түүнээс хойшхи тайлант жилээс хэрэгжиж эхлэх ба энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно.

² 2014 оны 7-р сарын 1-нээр эхэлсэн эсвэл түүнээс хойшхи тайлант жилээс хэрэгжиж эхлэх ба энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно.

³ 2016 оны 1-р сарын 1-нээр эхэлсэн эсвэл түүнээс хойшхи тайлант жилээс хэрэгжиж эхлэх ба энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно.

⁴ 2017 оны 1-р сарын 1-нээр эхэлсэн эсвэл түүнээс хойшхи тайлант жилээс хэрэгжиж эхлэх ба энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно.

⁵ 2018 оны 1-р сарын 1-нээр эхэлсэн эсвэл түүнээс хойшхи тайлант жилээс хэрэгжиж эхлэх ба энэ хугацаанаас өмнө хэрэгжүүлж болно.

СТОУС 9 Санхүүгийн Хэрэгсэл

2009 оны 11 сард гарсан СТОУС 9-д санхүүгийн хөрөнгийн ангилал болон хэмжилтийн шинэ шаардлагуудыг танилцуулсан. СТОУС 9-г 2010 оны 10 сард шинэчилж, санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт, түүнийг бүртгэлээс хасах шаардлагуудыг багтаасан, мөн 2013 оны 11 сард ерөнхий хейджийн нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагуудыг нэмж өөрчилсөн. Мөн 2014 оны 7 сард дахин шинэчилсэн бөгөөд үүнд санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэх шаардлага болон энгийн өрийн хэрэгслийн шинэ ангилал болох “бодит үнэ цэнээр бүртгэгдэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнадаг” санхүүгийн хэрэгслийн ангилал болон хэмжилтийн шаардлагуудыг багтаасан.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

СТОУС 9 Санхүүгийн Хэрэгсэл (Үргэлжлэл)

СТОУС 9-ийн гол шаардлагууд:

- НББОУС 39 – н хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүх санхүүгийн хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Ялангуяа, бизнесийн зарчмын дагуу гэрээгээр үүрэг хүлээсэн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн хамт төлөгдөх өрийн хөрөнгө оруулалтын тухайд төлөгдөөгүй үлдэгдэл нь дараагийн тайлант үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ. Бизнесийн зарчмын дагуу санхүүгийн хөрөнгө борлуулах болон гэрээгээр хүлээсэн мөнгөн урсгалыг хамтад нь цуглуулахаар гэрээгээр үүрэг хүлээсэн санхүүгийн хөрөнгө нь үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн хамт тусгай тогтоосон хугацаанд төлөгдөх өрийн хэрэглүүр байвал бодит үнэ цэнээр бүртгэгдэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Бусад бүх өрийн болон өмчийн хөрөнгө оруулалтыг дараагийн тайлант үеийн эцэст бодит үнэ цэнээр хэмжинэ.

Мөн түүнчлэн, СТОУС 9 дээр, аж ахуй нэгж бусад дэлгэрэнгүй орлого дах өмчийн хөрөнгө оруулалтын (худалдан борлуулах зорилгогүй) бодит үнэ цэнийн дараа үеийн өөрчлөлтийг өнөөгийн сонголт руу буцааж бүртгэхгүйгээр зөвхөн ногдол ашгийн орлогыг ашиг алдагдлаар бүртгэнэ.

- НББОУС 9 Бодит үнэ цэнээр бүртгэгдэж, өөрчлөлт нь ашиг алдагдлаар тайлагнагддаг санхүүгийн өр төлбөрийн хэмжилтийн тухайд тухайд, уг санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн зээлийн эрсдэлд нөлөөлөх хэсгийг уг санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдэлд нөлөөлөх хэсэг нь ашиг алдагдалд бүртгэлийн зөрүү үүсгэхээс бусад тохиолдолд бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдэлд нөлөөлөх бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дараагийн тайлант үеүдэд ашиг эсвэл алдагдал руу дахин ангилахгүй. НББОУС 39-д зааснаар бодит үнэ цэнээр бүртгэгдэж, өөрчлөлт нь ашиг алдагдлаар тайлагнагддаг санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн бүх өөрчлөлт нь ашиг алдагдлаар тайлагнагддаг.
- Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотойгоор, СТОУС 39 дэх бодит зээлийн алдагдлын загвараас татгалзан НББОУС 9 дэх хүлээгдэж буй эрсдлийн загварийг шаарддаг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвар нь зээлийг анх уг бүртгэлд тусгаснаас хойш зээлийн эрсдэлд орсон өөрчлөлтөнд нөлөөлж байвал уг хүлээгдэж буй эрсдлийн алдагдал болон тайлант хугацааны эцэст эдгээр хүлээгдэж буй алдагдлын өөрчлөлтийг бүртгэхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл зээлийн алдагдлын үйл явдал тохиолдохоос өмнө зээлийн эрсдлийн алдагдлыг бүртгэнэ.
- Шинэ ерөнхий хейджийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурууд нь СТОУС 39 дэх одоогоор боломжтой байгаа хейджийн нягтлан бодох бүртгэлийн 3 төрлийн механизмыг үлдээсэн. НББОУС 9-д зааснаар, хейджийн нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээний төрлөөр илүү уян хатан танилцуулсан. Ялангуяа хейджийн нягтлан бодох бүртгэлд тохирох хейджийн хэрэглүүрийг үнэлэх болон санхүүгийн бус зүйлсийн эрсдлийн бүрэлдэхүүний төрөл болох хэрэглүүрийн төрлүүдийг өргөтгөсөн. Мөн түүнчлэн, үр ашигт тест нь “эдийн засгийн харилцаа”-ны зарчмаар нарийвчлан хянагдаж солигдсон. Үр ашигт хейджийг ухрааж мөрдөх үнэлгээг цаашид хийх шаардлагагүй болсон. Аж ахуйн нэгжийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа хэмээх нэмэлт тодруулгын шаардлагуудыг танилцуулсан

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

СТОУС 9 Санхүүгийн Хэрэгсэл (Үргэлжлэл)

Банкны удирдлага энэхүү СТОУС 9-н хэрэгжилт нь ирээдүйд Банкны санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн тайлагналд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй гэж урьдчилан таамаглаж байна. Хэдий тийм боловч уг нөлөөллийг дэлгэрэнгүй нарийвчлан шалгах хүртэл тооцоолол хийж хэрэгжүүлэх боломжгүй байна.

СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого

Аж ахуйн нэгжүүд худалдан авагчтай байгуулсан гэрээнээс үүссэн орлогыг бүртгэхэд хэрэглэгдэх цорын ганц иж бүрэн загвар болгох зорилгоор СТОУС 15-г 2014 оны 5 сард батлан гаргасан. СТОУС 15 хүчин төгөлдөр болох үеэс эхлэн одоогийн орлого хүлээн зөвшөөрөхөд ашиглагдаж буй НББОУС 18 Орлого, НББОУС 11 Барилгын гэрээ болон тэдгээртэй холбоотой Тайлбарууд хүчингүй болно.

СТОУС 15-н үндсэн зарчим нь аж ахуйн нэгжүүд худалдан авагчид амласан бараа, үйлчилгээнийхээ шилжүүлсэн хэсэгт ногдох, тэдгээр бараа үйлчилгээг хүргэснийхээ хариуд авах эрхтэй болсон дүнгээр орлого хүлээн зөвшөөрөх юм. Тухайлбал, энэхүү стандарт нь орлого хүлээн зөвшөөрөх 5 алхамт загварыг тусгасан:

Алхам 1: Худалдан авагчтай хийсэн гэрээ(нүүд)-г тодорхойлох

Алхам 2: Гэрээгээрх үүрэг хариуцлагын гүйцэтгэлийг тодорхойлох

Алхам 3: Ажил гүйлгээний үнийг тогтоох

Алхам 4: Ажил гүйлгээний үнийг гэрээгээрх үүрэг хариуцлагын гүйцэтгэлд хуваарилах

Алхам 5: Аж ахуйн нэгж үүрэг хариуцлагын гүйцэтгэл хангагдсан үед орлого хүлээн зөвшөөрөх

СТОУС 15-н дагуу, аж ахуйн нэгжүүд үүрэг хариуцлагын гүйцэтгэл хангагдсан үед орлого хүлээн зөвшөөрдөг өөрөөр хэлбэл гэрээгээр заасан тодорхой үүрэг хариуцлагын гүйцэтгэлтэй холбогдох бараа эсвэл үйлчилгээний хяналт нь худалдан авагчид шилжсэн үед орлого хүлээн зөвшөөрдөг. Цаашлаад тодорхой тохиолдлуудад орлого хэрхэн хүлээн зөвшөөрөхийг зааварласан жишээнүүдийг уг стандартад нэмж оруулж өгсөн. Мөн СТОУС 15-р дэлгэрэнгүй тодруулгуудыг шаардсан.

Банкны удирдлагууд СТОУС 15-г хэрэгжүүлэх үеийн нөлөөлөл нь Банкны санхүүгийн тайланд тусгагдсан дүн болон тодруулганд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй гэж урьдчилан таамаглаж байна. Хэдий тийм боловч, нарийвчилсан шалгалт хийхээс нааш СТОУС 15-н нөлөөллийн талаарх ул үндэслэлтэй тооцооллоор хангах боломжгүй байна.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

СТОУС 11-ийн өөрчлөлтүүд Хамтарсан үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмших үеийн нягтлан бодох бүртгэл

СТОУС 11-д орсон өөрчлөлтөөр СТОУС 3 Бизнесийн нэгдэл-д тодорхойлсон бизнесийн хамтарсан үйл ажиллагааг олж эзэмших ажил гүйлгээг хэрхэн бүртгэх удирдамжаар хангасан. Тухайлбал, уг өөрчлөлт нь СТОУС 3-т тодорхойлсон бизнесийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зарчмууд болон бусад стандартуудыг(жишээлбэл НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт-тай холбоотой үнэ цэнийн бууралтыг хамтарсан үйл ажиллагааг олж эзэмших үед хуваарилагдсан гүүдвиллийг мөнгө үүсгэгч нэгжээр тестлэх) мөрдөх шаардлагатайг тусгасан. Хэрэв одоогийн бизнест хамтарсан үйл ажиллагаанд оролцогч аль нэг тал нь хувь нийлүүлсэн тохиолдолд л хамтарсан үйл ажиллагааны загварт мөрдөгдөх шаардлагууд хэрэгжинэ.

Хамтарсан үйл ажиллагаанд оролцогч тал нь мөн СТОУС 3 болон бизнесийн нэгдэлтэй холбоотой бусад стандартуудаар шаардсан холбогдох мэдээллийг тодруулахыг шаардсан.

СТОУС 11-н өөрчлөлт нь 2016 оны 1 сарын 1-с хойш эсвэл тухайн өдрөөр санхүүгийн жил нь эхлэх үед хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнэ.

Банкны удирдлагууд нь СТОУС 11-т орсон өөрчлөлтүүдийн хэрэгжилт нь ирээдүйд Банкны санхүүгийн тайлан болон тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

НББОУС 16 болон НББОУС 38-ийн өөрчлөлтүүд Элэгдэл ба Хорогдлын Зохистой Аргачлал

НББОУС 16-ийн нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгжүүд үндсэн хөрөнгийн орлогод суурилсан элэгдлийн аргыг ашиглахыг хориглосон. НББОУС 38-ын нэмэлт өөрчлөлтөд орлогод үндэслэн биет бус хөрөнгийн хорогдлыг тооцох нь зохистой суурь биш гэсэн зарчмыг агуулсан. Энэхүү таамаглал нь зөвхөн дараах хоёр хязгаарлагдмал нөхцөл биелсэн тохиодолд хүчингүй болно:

- Хэрэв биет бус хөрөнгө нь орлогыг хэмжих илэрхийлэл бол; эсвэл
- Хэрэв биет бус хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн хэрэглээ ба орлого нь өндөр хамааралтай гэдгийг харуулж байвал.

Нэмэлт өөрчлөлтүүдийг 2016 оны 1 сарын 1-нд эсвэл түүнээс хойшхи жилийн тайлант хугацаанд хэрэглэнэ. Одоогийн байдлаар Банк нь үндсэн хөрөнгийн элэгдэл ба биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар элэгдүүлж байна.

Банкны удирдлага шулуун шугамын арга нь тухайн хөрөнгийг ашигласны эдийн засгийн үр өгөөжийн хэрэглээг илэрхийлэх хамгийн зохимжтой арга гэж үзэж байна. Мөн түүнчлэн, НББОУС 16 ба НББОУС 38-д орох энэхүү нэмэлт өөрчлөлтийн хэрэгжүүлэлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж Банкны удирдлага үзэж байна.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

НББОУС 16 болон НББОУС 41-т орсон өөрчлөлтүүд *Хөдөө аж ахуй: Үр өгөөжтэй ургамал*

НББОУС 16 ба НББОУС 41-ийн нэмэлт өөрчлөлтүүд нь үр өгөөжтэй ургамлыг тодорхойлсон бөгөөд үр өгөөжтэй ургамлын тодорхойлтонд орж буй биологийн хөрөнгийг НББОУС 41-ийн дагуу биш НББОУС 16-ийн дагуу үндсэн хөрөнгөөр бүртгэхийг шаардсан. Үр өгөөжтэй ургамлаас гарч буй бүтээгдэхүүнийг НББОУС 41-ийн дагуу бүртгэнэ.

Банк нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй учраас НББОУС 16 ба НББОУС 41-д орох энэхүү нэмэлт өөрчлөлтийн хэрэгжүүлэлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж Банкны удирдлага үзэж байна.

НББОУС 19-д орсон өөрчлөлт *Тэтгэвэр Тэтгэмжийн Төлөвлөгөө: Ажилчдын Хувь Нэмэр*

НББОУС 19-ийн нэмэлт өөрчлөлт нь ажилчдын үзүүлсэн үйлчилгээний хугацаанаас хамааран тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөөг тодорхойлон, ажилчид эсвэл гуравдагч этгээдийн хувь нэмрийг хэрхэн бүртгэх талаар тодруулсан байна.

Үзүүлсэн үйлчилгээний хугацаанаас хамаарахгүй хувь нэмрийг аж ахуйн нэгж нь үйлчилгээ үзүүлсэн тайлант үеийн үйлчилгээний өртгийг бууруулж эсвэл төсөвлөсөн нэгжийн зээлийн аргыг ашиглан ажилчдын үзүүлсэн үйлчилгээний хугацаанд хамааруулан бүртгэнэ. Ажилтны үзүүлсэн үйлчилгээний хугацаанаас хамаарсан хувь нэмрийг аж ахуйн нэгж нь ажилчдын үзүүлэх үйлчилгээний хугацаанд хамааруулан бүртгэхийг шаардсан.

Банкны удирдлага нь НББОУС 19-д орсон эдгээр өөрчлөлтүүдийн хэрэгжилт нь Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

СТОУС-ын 2010-2012-ын мөчлөгт хийгдсэн Жилийн сайжруулалтууд

СТОУС-ын 2010-2012-ын мөчлөгт хийгдсэн жилийн сайжруулалтууд нь дараах СТОУС-д өөрчлөлт оруулсан байна:

СТОУС 2 —(i) 'баталгаажих нөхцөл' болон 'зах зээлийн нөхцөл'-ийн тодорхойлолтыг өөрчилсөн, (ii) өмнө нь 'баталгаажих нөхцөл'-ийн тодорхойлтонд хамаарч байсан 'гүйцэтгэлийн нөхцөл' ба 'үйлчилгээний нөхцөл'-ийн тодорхойлолтыг тус тус нэмсэн. СТОУС 2-ын өөрчлөлтүүд нь 2014 оны 7-р сарын 1-нээс хойш батлагдсан хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээнд хамаарна.

СТОУС 3-ын өөрчлөлтүүд нь хөрөнгө болон өр төлбөрөөр ангилагдсан болзошгүй төлбөрийг тайлант хугацаа бүрт бодит үнэ цэнээр хэмжихийг тодотгосон, болзошгүй төлбөр нь СТОУС 9 болон НББОУС 39-д хамаарах санхүүгийн хэрэглүүр эсвэл санхүүгийн бус хөрөнгө болон өр төлбөр бол хамаарахгүй. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (тайлант хугацааны хэмжилтийн тохируулгаас бусад) ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. СТОУС 3-ийн уг өөрчлөлтүүд нь 2014 оны 7-р сарын 1 эсвэл түүнээс хойш эзэмшсэн бизнесийн нэгдэлд хамаарна.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

СТОУС-ын 2010-2012-ын мөчлөгт хийгдсэн Жилийн сайжруулалтууд (үргэлжлэл)

СТОУС 8-ын өөрчлөлтүүд нь (i) аж ахуйн нэгжийг үйл ажиллагааны сегментийн нэгдлийн тодорхойлолт болон үйл ажиллагааны сегментүүд нь “эдийн засгийн ойролцоо шинж чанар”-тай эсэхийг тодорхойлохдоо үнэлсэн эдийн засгийн үзүүлэлтүүдийг хамруулсан үйл ажиллагааны сегментийг нэгтгэх шалгуурт ашигладаг удирдлагын үнэмлэмжийг тодруулахыг шаардсан. (ii) Хэрэв сегментийн хөрөнгө үйл ажиллагааны гол шийдвэр гаргагчид тогтмол тайлагнагддаг бол зөвхөн тайлагнаж байгаа сегментүүдийн аж ахуйн нэгжийн нийт хөрөнгө рүү тохируулсан тохируулгыг тайлагнахыг тодотгосон.

СТОУС 13-ын дүгнэлтийн үндэслэлүүдийн өөрчлөлтүүд нь шинээр гарч буй СТОУС 13 болон СТОУС 9 ба НББОУС 39-ийн өөрчлөлт нь хэрэв дискаунтын нөлөөлөл нь материаллаг биш бол нэхэмжлэх дээр хүүгийн хувь хэмжээг заагаагүй богино хугацаат авлага болон өглөгийг хэмжихийг хасаагүйг тодотгосон. Өөрчлөлтүүд нь ямар нэг хэрэгжих хугацаа заагаагүй нь тэдгээрийг яаралтай хэрэгжүүлэхийг анхааруулсан.

НББОУС 16 болон НББОУС 38-ын өөрчлөлтүүд нь үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийг дахин үнэлэх үеийн хуримтлагдсан элэгдэл/хорогдлын бүртгэлийн нийцгүй байдлыг хассан. Өөрчлөгдсөн стандартаар үндсэн хөрөнгийн нийт дүнг дансны үнийн дахин үнэлгээний дагуу тууштай залруулах, хуримтлагдсан элэгдэл/хорогдол нь нийт дансны үнэ болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг оруулж бодсоны дараах дансны үнийн зөрүү гэж тайлбарласан.

НББОУС 24-ын өөрчлөлтүүд нь менежментийн компани тайлагнагч аж ахуйн нэгжид менежментийн үйлчилгээ үзүүлсэн бол менежментийн компани нь аж ахуйн нэгжийн холбоотой тал болохыг тодотгосон. Ийм учраас тайлагнагч аж ахуйн нэгж холбоотой талын ажил гүйлгээндээ үйлчилгээнд төлсөн төлбөр болон менежментийн компанид өгөх өглөгийг тодруулах хэрэгтэй. Хэдий тийм боловч үндсэн удирдлагын цалин урамшууллын тодруулга шаардлагагүй.

Эдгээр өөрчлөлтүүдийн хэрэгжилт нь Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж Банкны удирдлага үзэж байна.

СТОУС-ын 2011-2013-ын мөчлөгт хийгдсэн Жилийн сайжруулалтууд

СТОУС-ын 2011-2013-ын мөчлөгт хийгдсэн жилийн сайжруулалтууд нь дараах СТОУС-д өөрчлөлт оруулсан байна.

СТОУС 3-ийн өөрчлөлтөөр хамтарсан хэлцлийн санхүүгийн тайланд хамтарсан хэлцлийн нягтлан бодох бүртгэлийг уг стандартад оруулаагүйг тодорхойлсон.

СТОУС 13-ийн өөрчлөлтөөр НББОУС 39 эсвэл СТОУС 9-ийн дагуу бүртгэгдсэн болон уг стандартуудын хүрээн дэх бүх гэрээнүүдийн цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтийн хүрээг тодорхойлсон. Хэдий тийм боловч дээрх гэрээнүүд нь НББОУС 32-ийн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтод нийцдэггүйг тодорхойлсон.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тодруулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

СТОУС-ын 2011-2013-ын мөчлөгт хийгдсэн Жилийн сайжруулалтууд (үргэлжлэл)

НББОУС 40-ийн өөрчлөлтөөр НББОУС 40 болон СТОУС 3-ын харилцан уялдаа болон эдгээр стандартуудаар шаарддаг шаардлагуудыг ойлгомжтой болгосон. Мөн аж ахуй нэгж хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө олж эзэмшихдээ дараах зүйлсийг тодорхойлох ёстой:

- а) Хөрөнгө нь НББОУС 40-ийн дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолттой нийцэж байгаа эсэх; мөн
- б) Уг гүйлгээ нь СТОУС 3-ийн дагуу бизнесийн нэгдлийн тодорхойлолттой нийцэж байгаа эсэх.

Энэхүү нэмэлт өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж Банкны удирдлага үзэж байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

Гадаад валютын ханшийн тэгшитгэл

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийсэн өдрийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн албан ханшаар дахин хөрвүүлдэг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд “Бусад үйл ажиллагааны орлого” гэж бүртгэнэ. Түүхэн өртгөөрөө гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээрээ гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ нь тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Санхүүгийн хэрэглүүр - анхдагч хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Банк тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд “хэвийн нөхцөлтэй арилжаа” буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

(ii) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүд

Зах зээлийн эрсдлүүдийг удирдахын тулд Банк валютын ханшны форвард болон своп гэрээ хэлцлүүд гэсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашигладаг. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхдагч хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(ii) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүрүүдэд агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг салгаж авч үзэх ёстой ба тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүд нь агуулагч гэрээний эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүдтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анх хүлээн зөвшөөрөхдөө "Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэгдэх" гэж ангилаагүй тохиолдолд тэдгээрийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(iii) Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр

"Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. "Арилжааны цэвэр орлого"-д бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусгана. Хүү болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь "Арилжааны цэвэр орлого" дансанд бүртгэнэ.

Энэ бүлэгт ойрын хугацаанд борлуулах эсвэл эргүүлэн худалдан авах зорилгоор олж авсан өрийн бичгүүд, энгийн хувьцаа, үнэт цааснууд орсон.

(iv) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Энэ бүлгийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд нь удирдлага анх хүлээн зөвшөөрөхдөө энэ бүлэгт оруулахаар шийдвэрлэсэн санхүүгийн хэрэгслүүд байна. Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болох ба шийдвэрийг хэрэгсэл нэг бүр дээр гаргана. Үүнд:

- ▶ Энэхүү шийдвэр нь хөрөнгө, өр төлбөрийг хэмжих эсвэл хөрөнгө өр төлбөрөөс үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого, зардалд хүлээн зөвшөөрснөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвитойгоор бууруулахаар байвал;
- ▶ Эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл аль аль нь бөгөөд тэдгээрийг хүчин төгөлдөр эрсдлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдаж, гүйцэтгэлийг нь бодит үнэ цэнэ дээр нь суурилан хэмждэг байх;
- ▶ Гэрээнд зааснаас бусад тохиолдолд мөнгөн урсгалыг ихээхэн хэмжээгээр өөрчлөх нэг эсвэл түүнээс олон тооны санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг санхүүгийн хэрэгсэл нь агуулж байвал.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхдагч хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(iv) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр (Үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг "арилжааны цэвэр олз" дансанд бүртгэнэ. Олсон хүүгийн орлогыг "Хүүгийн орлого" дансанд, гарсан хүүгийн зардлыг "Хүүгийн зардал" дансанд үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хуримтлуулж бүртгэх ба ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь "Үйл ажиллагааны бусад орлого"-д бүртгэнэ.

2014 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэдэг санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр байхгүй.

(iv) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтанд өөрийн хөрөнгийн ба өрийн үнэт цааснууд багтана. "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" ба "бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх" гэсэн ангилалд ороогүй өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг "Борлуулахад бэлэн" гэж ангилна. Тодорхойгүй хугацаагаар эзэмших хандлагатай, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах үүднээс эсвэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас борлуулж болох өрийн үнэт цаасууд энэ ангилалд орно.

Банк нь аливаа зээл, авлагуудыг "Борлуулахад бэлэн" санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй. Анхны хэмжилтийн дараа борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Хэрэгжээгүй ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн (бусад дэлгэрэнгүй орлого) "Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц"-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өөрийн хөрөнгөнд өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлогын тайланд "Үйл ажиллагааны бусад орлого"-оор хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг "эхэлж авснаа эхэлж зарлагадах" зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогоор бүртгэнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлогын тайланд "Үйл ажиллагааны бусад орлого"-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайлангийн "Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал"-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасч өгнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхдагч хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(vi) Дуусвар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, тогтоосон хугацаатай, Банк дуусвар хугацаа хүртэл нь эзэмших хандлага болоод чадвартай, үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг "Дуусвар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт" гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусвар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Хүү болон түүнтэй адилтгах орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв Банк бага биш дүнтэй “дуусвар хугацаа хүртэл эзэмших” хөрөнгө оруулалтыг дуусвар хугацаанаас нь өмнө худалдах эсвэл дахин ангилах бол (зарим нэг онцгой тохиолдлуудаас бусад) нийт бүлгээр нь “борлуулахад бэлэн” бүлэгт дахин ангилна. Үүнээс гадна Банк нь дараагийн хоёр жилд “дуусвар хугацаа хүртэл эзэмших” бүлгээс аливаа нэг санхүүгийн хөрөнгийг дахин ангилахыг хориглодог.

(vii) Зээл ба урьдчилгаа

“Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа”-нд идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй дараахаас бусад үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүд багтана. Үүнд:

- ▶ Банк нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- ▶ Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- ▶ Банк зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас анх оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэглүүрүүд.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, “Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа”-г үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлогын тайлангийн "Хүү болон түүнтэй адилтгах орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхдагч хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(vii) Зээл ба урьдчилгаа (Үргэлжлэл)

Банк богино хугацаанд зээлийг зарах хандлагатай байгаа учраас уг зээлийг “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” гэж ангилахаар хүлээж байгаа үед Банк зээл олгох тодорхой нэг амлалтыг гаргаж болно. Эдгээр амлалтыг үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэж бүртгэж, бодит үнэ цэнээр нь хэмжин зөрүүг ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Зээлийг татан авах үед Банк зээлийг хадгалж үлдэх ба богино хугацаанд худалдахгүй гэсэн амлалт гаргасан бол энэ амлалтыг хэрэгжүүлэх нь төвөгтэй ба алдагдал хүлээх магадлалтай (жишээ нь: харилцагч талын зээлийн үйл явдлын улмаас) үед л энэ амлалтыг бүртгэнэ.

(viii) Зээлээр авсан санхүүжилт болон хоёрдогч өглөг

Зээлээр авсан санхүүжилт болон хоёрдогч өглөг нь гадаад дотоодын санхүүгийн байгууллагын өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг юм.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, зээл болон хоёрдогч өглөгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

Банкны зээлээр авсан болон хоёрдогч өглөгөөр авсан санхүүжилтийн шинжилгээг Тодруулга 27 болон 28-д тус тус толилуулсан.

(ix) Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж

Бусад банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд үүнд хамрагдана (Тодруулга 23).

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, зээллэгүүдийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

(x) Харилцагчдын харилцах, хадгаламж

Харилцагчдаас авсан харилцах, хугацаагүй болон хугацаатай хадгаламж хамрагдана (Тодруулга 26).

(xi) Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, харилцагчдын харилцах, хадгаламж үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхдагч хүлээн зөвшөөрөлт ба дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)

(xii) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

“Борлуулахад бэлэн” ангиллаас дахин ангилсан санхүүгийн хөрөнгүүд дээр өмнө нь хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд бүртгэсэн аливаа нэг олз гарзыг хөрөнгө оруулалтын үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, ашиг, алдагдлаар бүртгэнэ. Хорогдуулсан шинэ үнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хоорондох аливаа зөрүүг мөн хөрөнгийн үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд хөрөнгийг үнэ цэнийн бууралтанд орсон гэж тодорхойлбол өмнөх хугацаанд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн дүнг дэлгэрэнгүй орлогын тайлан руу шилжүүлэн бүртгэнэ.

Хэрэв хөрөнгө нь зээл ба авлага тодорхойлолтод нийцэж байгаа бөгөөд Банк хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусвар хугацаа хүртэл нь эзэмших хандлага ба чадвартай байгаа бол Банк үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” гэсэн ангиллаас “Зээл ба авлага” гэсэн ангилалд дахин ангилж болно. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан ба орж ирэх мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүгийн түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Дахин ангилал нь удирдлагын шийдвэрээс хамаарах ба хэрэглүүр тус бүр дээр тодорхойлно. Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа аливаа нэг санхүүгийн хэрэглүүрийг “Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх” бүлэгт дахин ангилаагүй.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ▶ Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- ▶ Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
- ▶ Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- ▶ Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (Үргэлжлэл)

(i) Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнхи эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

2014 онд Банк зарим орон сууцны зээлүүдийг хүлээн зөвшөөрөөгүй. (Тодруулга 18).

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('репо')-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнхи эрсдлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгөө хөрөнгөөр, репо хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тус тус тусгах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл ('урвуу репо')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд "Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа" гэж тусгах ба энэ нь Банкны авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг "Хүүгийн цэвэр орлого" гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (Үргэлжлэл)

Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд (Үргэлжлэл)

Хэрэв буцаан худалдах хэлцлээр худалдан авсан үнэт цаасыг гуравдагч талд худалдсан бол үнэт цаасыг буцаан өгөх үүргийг “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр” гэж бүртгэх ба бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн аливаа олз эсвэл гарзыг “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон дилерийн үнэ (урт позицгийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицгийн хувьд эрэлтийн үнэ) -н дээр үндэслэнэ.

Идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргачлал, зах зээлийн үнийн мэдээ нь байдаг ойролцоо төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулсан арга, опционы үнэлгээний загвар, зээлийн загвар болон бусад тохиромжтой аргууд багтана.

Зах зээлийн өнөөгийн үнэ цэнэ эсвэл зах зээлийн мэдээлэл нээлттэй биш үед үнэлгээний аргуудыг ашиглан тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Тэдгээрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит зах зээлийн гүйлгээний дүн болон үнийг тооцож үүнээс банк хамгийн тохиромжтой үнэлгээний загварыг ашигладаг. Позиц хаах үнэ, дебит кредит үнэлгээний тохируулга, хөрвөх чадварын зөрүү, тухайн загварын хязгаарлалтууд нь авах зарах үнийн зөрүүг тодорхойлоход нөлөөлөх бөгөөд тэдгээр нөлөөллийн хамрах хүрээгээр загварт тохируулга хийдэг. Түүнчлэн санхүүгийн хэрэгслийг анх бүртгэхдээ ашиг алдагдлыг хойшлуулах бөгөөд орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл хэрэглүүрийг дахин хүлээн зөвшөөрөх үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг тодруулга 35-д тодруулсан болно.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтанд орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтанд орсон гэж үзнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд (банкууд дахь харилцах, харилцагч нарт олгосон зээл ба урьдчилгаа, дуусвар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт)-ийн хувьд Банк эхлээд чухал ач холбогдол бүхий санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүгийн орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл банкинд шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл “Зээлийн алдагдлын зардал” дансны кредитэд бүртгэнэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд (Үргэлжлэл)

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүгийн хувь нь хувьсах байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Банк арилжааны зориулалттай хөрөнгийг “Зээл ба авлага” ангилалд дахин ангилсан бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь дахин ангилсан өдрийн шинэ үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтын багцын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдлийн шинж чанаруудыг харгалзан үзсэн банкны дотооддоо хэрэглэдэг зээллэгийн ангиллын систем дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг бүлэглэнэ.

Эрсдлийн бүлэг тус бүр дээр түүхэн дундаж алдагдлыг харгалзах зээлийн үлдэгдэлд нь хувааж үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцох энгийн аргачлалыг сонгосон. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

(i) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө орлуулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтанд орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

Борлуулахад бэлэн гэж ангилагдсан өрийн хэрэгслийн хувьд Банк хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгөтэй адил шалгуураар хөрөнгө оруулалт тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлж үзнэ. Гэсэн хэдий ч, үнэ цэнийн бууралтаар бүртгэх дүн нь хуримтлагдсан алдагдал (хорогдуулсан өртөг болон өнөөгийн бодит үнэ цэнийн зөрүүнээс тухайн хөрөнгө оруулалттай холбоотой дэлгэрэнгүй орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрч байсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжих) байна. Ирээдүйн хүүгийн орлого нь бууруулсан бүртгэлийн үнэ дээр суурилах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах зээлийн үйл явдлын улмаас өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ өсөж эсвэл буурвал, үнэ цэнийн бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан буцаана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өмчийн хөрөнгө оруулалтын хувьд, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байвал бодит нотолгоонд багтана. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өмчийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

(ii) Зээлийн шинэчилсэн гэрээ

Хэрэв боломжтой бол банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохоос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцлийг санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм. Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол аливаа нэг үнэ цэнийн бууралтыг зээлийн нөхцлийг өөрчлөхөөс өмнө тооцож байсны нэг адил анхны үр ашигт хүүгийн аргыг ашиглан хэмжих ба зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүгийн хувиар тооцдог тусгайлсан болон багцын үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байна.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэр дүнгээр тайлагнах

Зөвхөн хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэврээр барагдуулах хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа тохиолдолд л санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр нь тайлан тэнцэлд толилуулж болно. Мастер үр дүнгийн тооцооны гэрээнүүдийн хувьд энэ нөхцлүүд ерөнхийдөө хэрэгждэггүй учраас холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулдаг.

“Эхний өдөр”-ийн ашиг алдагдал

Ажил гүйлгээний үнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн ажил гүйлгээний бодит үнэ цэнээс ялгаатай эсвэл нээлттэй зах зээлийн мэдээллийн үнэлгээний аргад суурилсан байвал Банк бодит үнэ цэнэ, ажил гүйлгээний үнийн зөрүүг шууд бусад үйл ажиллагааны цэвэр орлогоор хүлээн зөвшөөрнө (Эхний өдрийн ашиг ба алдагдал). Илэрхий нээлттэй мэдээлэлд суурилаагүй бол ажил гүйлгээний үнэ болон үнэлгээний загварын зөрүүг орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх үед дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэхийг үнэлж үзэх шаардлагатай.

Банк түрээслэгчээр

Банкинд түрээслэж байгаа хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлэхгүй байгаа тохиолдолд түрээсийн гэрээ нь үйл ажиллагааны түрээс байна. Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар бүртгэнэ.

Банк түрээслүүлэгчээр

Түрээслүүлэгч нь хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдлийг хүлээж, өгөөжийг хүртэж байгаагаас бусад түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Үйл ажиллагааны түрээсийн гэрээг анх байгуулахад гарсан шууд зардлуудыг түрээслэсэн хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмэх ба түрээсийн хугацаанд түрээсийн орлогыг зөвшөөрөхтэй адил аргаар хүлээн зөвшөөрнө.

Түрээслэгчээс санхүүгийн түрээсийн авах авлагын дүнг тодорхойлохдоо Банкны түрээсийн хөрөнгөнд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын дүнгээр хүлээн зөвшөөрнө. Банкны хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтмол байлгахын тулд санхүүгийн түрээсийн орлогыг бүртгэлийн хугацаанд хувиарлан хүлээн зөвшөөрнө.

Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Банкинд орж ирэх нь тодорхой мөн хэмжих боломжтой үед орлогыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

(i) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэглүүрүүд, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан хүүтэй санхүүгийн хөрөнгүүд, “Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) хэрэглэн бүртгэнэ.

Тооцоололд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэглүүрт шууд хамааралтай ба зээлийн ирээдүйн алдагдал биш харин үр ашигт хүүгийн салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаасан.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх (Үргэлжлэл)

(i) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал (Үргэлжлэл)

Банк хийх төлбөр, хүлээн авах мөнгөний талаар хийсэн өөрийн тооцоололдоо өөрчлөлт оруулбал санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүнг залруулна. Залруулсан бүртгэлийн дүнг анхны үр ашигт хүүгийн түвшин дээр үндэслэн тооцоолох ба бүртгэлийн дүнгийн зөрүүг “Бусад үйл ажиллагааны орлого” гэж бүртгэнэ. Гэхдээ ирээдүйд хүлээн авах мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний тооцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүгийн түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн эсвэл төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн бүртгэлийн дүнг үнэ цэнийн бууралтын алдагдлын улмаас бууруулсан бол үнэ цэнийн бууралтыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахдаа хэрэглэсэн хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө.

(ii) Хураамж ба шимтгэлийн орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамжийн орлогыг дараах хоёр бүлэгт хувааж болно. Үүнд:

Тодорхой хугацааны туршид үзүүлж байгаа үйлчилгээнүүдээс олсон хураамжийн орлого

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжинд шимтгэлийн орлого, хөрөнгийн удирдлага, хамгаалалтын болон бусад удирдлага, зөвлөгөөний хураамжууд орно.

Татан авах нь тодорхой зээлүүд дээр “Зээлийн үйлчилгээний шимтгэл”-ийг хойшлуулах (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) ба зээлийн үр ашигт хүүгийн залруулга гэж хүлээн зөвшөөрнө. Татан авахгүй нь бараг тодорхой болсон зээлүүдийн “Зээлийн үйлчилгээний шимтгэл”-ийг үүрэг хүлээсэн хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

Гүйлгээний үйлчилгээний хураамжийн орлого

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсвэл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсвэл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уягдсан хураамж эсвэл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх (Үргэлжлэл)****(iii) Арилжааны цэвэр орлого**

Арилжааны үйл ажиллагааны үр дүнд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн бүх олз, гарз ба холбогдох хүүгийн орлого, зардал, “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн ногдол ашиг орно.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайланд тайлагнасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь мөнгө, Монголбанкн дахь хязгаарлалтгүй харилцах данс, бусад банкуудад байршуулсан харилцах ба 3 сар түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг анхлан өртгөөр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмж эсвэл зохистой бол тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацааны дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Барилга	40 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Компьютер, техник хэрэгсэл	5 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Түрээсийн хөрөнгийн сайжруулалт	Түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацааны аль багад

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг олохгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн программ хангамж, лиценз, патент, эрхийн өртөг орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлэнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалт нь тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн өртгийг дараах ойролцоогоор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна. Үүнд:

Компьютерийн програм хангамж	2-10 жил
Патент ба эрхүүд	3 – 60 жил

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтанд орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтанд орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгчийг тодорхойлохдоо, нийтэд хувьцаагаа арилжаалдаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдийг ашиглан хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө үүсгэгч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн баталгаа

Бизнесийн хэвийн нөхцөлд Банк аккредитив, баталгаа, хүлээн зөвшөөрөлт гэх мэт санхүүгийн баталгааг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр "Бусад өр төлбөр"-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Санхүүгийн баталгаа (Үргэлжлэл)

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Үнэ цэнийн бууралтын алдагдал" дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Хураамж, шимтгэлийн цэвэр орлого" дансанд хүлээн зөвшөөрнө.

Ажилчдын тэтгэвэр тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

(ii) Тогтоогдсон тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөө

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Банк мөн өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны банкинд ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэдэг.

Сангууд

Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг хариуцлага (хуулийн эсвэл үүсмэл) байгаа ба уг үүрэг хариуцлагыг биелүүлэхэд эдийн засгийн гадагш урсгал гарах магадлалтай болсон бөгөөд дүнг нь ул үндэслэлтэй тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа сантай холбоотой зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Татвар

(i) Тайлант хугацааны орлогын татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Татвар (Үргэлжлэл)

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хоорондын түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ▶ Хэрэв хойшлогдсон татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.

Дараахаас бусад бүх хасагдах түр зөрүүнүүд, ашиглаагүй татварын хөнгөлөлт, ашиглаагүй татварын алдагдлууд дээр, эдгээрийг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа үед хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ▶ Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол;
- ▶ Охин компанид оруулсан хөрөнгө орлуулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого олох магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олох эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Татвар (Үргэлжлэл)

(ii) Хойшлогдсон татвар (Үргэлжлэл)

Эздийн өмчид шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлогдсон татварыг мөн эздийн өмчид хүлээн зөвшөөрөх ба дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнаж болно.

Энгийн хувьцааны ногдол ашиг

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ба Банкны хувьцаа эзэмшигчид баталсан үед өөрийн хөрөнгөөс хасна. Хугацааны дундуурх ногдол ашгийг зарласан, Банк буцаах аргагүй болсон үед өөрийн хөрөнгөөс хасна.

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараа батлагдсан тайлант жилийн ногдол ашгийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах үйл явдал гэж толилуулна.

Эцдийн өмчийн нөөцүүд

Банкны санхүүгийн байдлын тайлан дээрх эздийн өмч (бусад дэлгэрэнгүй орлого)-д бүртгэгдсэн нөөцөд дараах нөөцүүд орно. Үүнд:

“Бусад нөөц” нь Банкны захирлуудын зөвлөлийн шийдвэр дээр үндэслэсэн хуримтлагдсан ашгийн ашиглалтыг илэрхийлдэг. Бусад нөөцийн зорилгыг одоогийн байдлаар тодорхойлоогүй байна. Бусад нөөц нь Банкны үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглагдах ба ногдол ашгийн төлбөрт ашиглагдахгүй.

Засгийн газрын нөхцөлт хандив

Засгийн газрын нөхцөлт хандивыг хүлээн авах нь тодорхой болсон ба дагалдах бүх нөхцлүүдэд нийцнэ гэж үзэж байгаа үед хүлээн зөвшөөрнө. Нөхцөлт хандив нь зардлын зүйлтэй холбогдож байгаа үед нөхцөлт хандивыг нөхөн олгох хандлагатай зардлуудтай тааруулахад шаардагдах хугацааны туршид орлогоор хүлээн зөвшөөрнө. Нөхцөлт хандив нь хөрөнгөтэй холбогдож байгаа үед үүнийг хойшуулсан орлогоор хүлээн зөвшөөрөх ба холбогдох хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид тэнцүү хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрнө.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Засгийн газрын нөхцөлт хандив (Үргэлжлэл)

Банк мөнгөн бус нөхцөл хандивыг хүлээн авч байгаа үед хөрөнгө ба нөхцөлт хандивыг нийт нэрлэсэн дүнгээр нь бүртгэх ба хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид ба холбогдох хөрөнгийн өгөөжийг хэрэглэх хэлбэрээс хамааран жил бүр адил хэмжээтэйгээр орлогын тайлан руу бичнэ. Засгийн газар эсвэл холбогдох байгууллагаас зээл эсвэл төсөөтэй тусламжийг өнөөгийн хэрэгжиж буй зах зээлийн хүүгээс бага хүүтэйгээр олгож эсвэл үзүүлж байгаа үед энэхүү тааламжтай хүүгийн нөлөөллийг засгийн газраас олгож буй нэмэлт нөхцөлт хандив гэж үзнэ.

Үнэт металл

Зоос болон соёлын үнэт зүйлсийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь тусгана.

Хураан авсан хөрөнгүүд

Банкны бодлого нь хураан авсан хөрөнгүүдийг дотоод үйл ажиллагаандаа ашиглах эсвэл худалдан борлуулахыг тодорхойлдог. Дотоод үйл ажиллагаандаа ашиглахаар тодорхойлогдсон хөрөнгүүд нь холбогдох хөрөнгийн данс руу шилждэг. Худалдан борлуулахаар тодорхойлогдсон хөрөнгүүдийг “Борлуулах зориулалттай хөрөнгө”-ийн данс руу шилжүүлдэг. Ашиглалтыг нь банк тодорхойлоогүй хураан авсан хөрөнгүүдийг энэ дансанд бүртгэсэн болно.

Хураан авсан хөрөнгүүдийг анхлан тэдгээрийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба холбогдох зээлийн буцаан авалт хийгдсэн өдрийн байдлаарх үлдэгдэл дүнгийн аль багаар нь хүлээн зөвшөөрөх ба холбогдох зээл ба урьдчилгааг үнэ цэнийн бууралтын сангийнх нь хамт тайлан тэнцэлд үл хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант хугацаанд хураан авсан хөрөнгийг өртөг ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь хэмжиж, “Бусад хөрөнгө”-нд бүртгэнэ.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг дансны үнэ болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар үнэлнэ. Хураан авсан хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглахаас илүү борлуулснаар үлдэгдэл өртгийг нөхөх боломжтой бол уг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөд ангилна. Энэ нөхцлийг хангахын тулд хураан авсан хөрөнгө нь зах зээл дээр тохиромжтой үнээр идэвхтэй арилжаалагдах, хөрөнгө болон худалдах багц нь өөрийн одоо байгаа нөхцөл байдлаараа түргэн борлогдох боломжтой, удирдлага худалдан борлуулахаар төлөвлөж байгаа, нэг жилийн дотор борлуулах магадлал өндөртэй байх ёстой.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Сегментийн тайлагнал

Банкны сегментийн тайлагнал нь дараах үйл ажиллагааны сегментүүд дээр суурилсан байдаг: иргэдийн банк, бизнесийн банк, орон сууцны банк, хөрөнгө зохицуулалтын хэлтэс.

Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашгийг тайлант хугацааны туршид гаргасан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашиг дээр аливаа татварын нөлөөллийг оруулсан хөрвөгч давуу эрхтэй хувьцаа болон хөрвөгч бонд (хорогдуулагч үнэт цаас)-ын хүүг нэмж, уг дүнгээ хэрвээ хорогдуулагч үнэт цааснуудыг бүгдийг нь хөрвүүлсэн тохиолдолд нэмж гаргах байсан энгийн хувьцааны тоог оруулсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Санхүүгийн тайлагналын зорилгоор дараах этгээдүүдийг банкны холбоотой талууд хэмээн авч үзнэ. Үүнд:

- ▶ Банкны удирдлага, бодлого, эрхлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэрт шууд буюу шууд бус байдлаар, дангаараа буюу бусадтай хамтрах хэлбэрээр хяналт тогтоож нөлөөлдөг, эсхүл нөлөөлөх боломж бүхий тал;
- ▶ Банктай нэгдмэл сонирхолтой этгээд;
- ▶ Банкны гол удирдах албан тушаалтнууд, тэдний эцэг эх, гэр бүлийн гишүүн, эсвэл тэдний шууд буюу шууд бусаар хяналтаа хэрэгжүүлдэг хуулийн этгээд;
- ▶ (л)-д заасан иргэдийн гэр бүлийн гишүүд, эсвэл тэдгээрийн шууд буюу шууд бусаар хяналтаа хэрэгжүүлдэг хуулийн этгээд; эсвэл
- ▶ Банк болон түүнтэй холбоотой талын ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог этгээд

Ойрын садан төрөл гэж иргэний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, тэдгээр нь шууд буюу шууд бус хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлдэг хуулийн этгээд, түүний нэгдмэл сонирхолтой этгээд

Холбоотой талуудтай хийсэн бүх гүйлгээ болон дансдын үлдэгдлийн мэдээллүүдийг санхүүгийн тайланд хавсаргасан бөгөөд Тодруулга 38-д задаргааг толилуулсан.

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ

Удирдлагын зорилгоор Банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээн дээрээ суурилан үйл ажиллагааны дараах дөрвөн сегментэд хуваагддаг. Үүнд:

Иргэдийн банк	- Харилцагчдын харилцах данс, хадгаламжийн данс, дебет болон кредит карт, бичил бизнесийн зээл, хэрэглээний зээл, санхүүгийн түрээс, эко зээл, төлбөр шилжүүлгүүд.
Бизнесийн банк	- Жижиг дунд үйлдвэр болон банкны харилцагчдад үзүүлдэг арилжааны банкны үйл ажиллагаа нь дебет хэрэгслүүд, харилцах данс, хадгаламж, овердрафт, зээл, худалдааны санхүүжилт, бусад кредит хэрэгслүүд, олон улсын шилжүүлэг.
Орон сууцны банк	- Орон сууц худалдан авахад зориулсан зээлүүд, арилжааны хөрөнгө худалдан авахад зориулсан орон сууцны зээлүүд, орон сууцны хадгаламжийн бүтээгдэхүүн.
Хөрөнгө зохицуулалтын хэлтэс	-Бэлэн мөнгөний удирдлага, Монголбанкны үнэт цаас, банк хоорондын зээл, хадгаламж, санхүүгийн хэрэглүүрийн арилжаа.

Банкны удирдлага нь нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээний талаар шийдвэр гаргахдаа хэрэглэх зорилгоор өөрийн бизнесийн үйл ажиллагааны үр дүнг тусад нь хянаж байдаг. Сегментийн гүйцэтгэлийг үйл ажиллагааны ашиг, алдагдал (зарим тохиолдолд санхүүгийн тайлангууд дээрх үйл ажиллагааны ашиг алдагдлаас өөрөөр хэмждэг) дээр нь үндэслэн үнэлдэг. Орлогын татварыг банкны түвшинд удирддаг ба сегментүүдэд хуваарилдаггүй.

Удирдлага нь гүйцэтгэлийн хэмжүүр нь нийт орлого, зардал биш цэвэр хүүгийн орлого байдаг учраас хүүгийн орлогыг цэвэр дүнгээр нь тайлагнадаг.

Үйл ажиллагааны сегментүүдийн хооронд шилжих үнэ нь гуравдагч талтай хийж байгаа гүйлгээний нэг адил зарчмаар тооцогддог.

2014 ба 2013 онуудын аль алинд нэг хөндлөнгийн харилцагч эсвэл талтай хийсэн гүйлгээний орлого нь Банкны нийт орлогын 10%-иас илүү гараагүй.

БҮС НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

2014 болон 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон тайлант жилүүдэд Банкны бүхий л үйл ажиллагаа Монгол Улсад хийгдсэн. Ийм учраас бүс нутгийн мэдээлэл толилуулагдаагүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэнд Банкны 2014 оны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба тодорхой хөрөнгө, өр төлбөрийн талаарх мэдээллийг толилуулалаа.

	Иргэдийн банк 2014 мян.төг	Бизнесийн банк 2014 мян.төг	Орон сууцны банк 2014 мян.төг	Хөрөнгө зохицуулалтын хэлтэс 2014 мян.төг	Хуваарилаг- даагүй 2014 мян.төг	Нийт 2014 мян.төг
Орлого						
Гуравдагч тал	37,345,379	73,628,735	19,542,008	(34,540,555)	327,096	96,302,663
Сегмент хоорондын	14,525,727	(16,989,656)	(6,557,501)	9,021,430	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	51,871,106	56,639,079	12,984,507	(25,519,125)	327,096	96,302,663
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(4,094,505)	(24,712,463)	(969,529)	-	(110,801)	(29,887,298)
Үйл ажиллагааны цэвэр орлого	47,776,601	31,926,616	12,014,978	(25,519,125)	216,295	66,415,365
Үр дүнгүүд						
Хүүгийн цэвэр орлого (зардал)	34,194,386	70,139,266	19,469,050	(26,393,545)	-	97,409,157
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	3,112,637	3,486,003	72,959	-	-	6,671,599
Арилжааны цэвэр алдагдал	-	-	-	54,028	-	54,028
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(388,229)	(127,536)	-	(4,712)	(3,734,911)	(4,255,388)
Биет бус хөрөнгийн хорогдол	-	-	-	-	(986,182)	(986,182)
Сегментийн ашиг (алдагдал)	44,334,355	29,998,036	12,014,979	(25,599,310)	(48,540,026)	12,208,034
Орлогын татварын зардал	-	-	-	-	(572,326)	(572,326)
Тайлант жилийн ашиг	44,334,355	29,998,036	12,014,979	(25,599,310)	(49,112,352)	11,635,708
Хөрөнгө						
Капитал зардал						
Үндсэн хөрөнгө	-	-	-	-	6,506,999	6,506,999
Бусад биет бус хөрөнгө	-	-	-	-	4,371,886	4,371,886
	-	-	-	-	10,878,885	10,878,885

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Иргэдийн банк 2014 мян.төг	Бизнесийн банк 2014 мян.төг	Орон сууцны Банк 2014 мян.төг	Хөрөнгө зохицуулалтын хэлтэс 2014 мян.төг	Хуваарилаг- даагүй 2014 мян.төг	Нийт 2014 мян.төг
Нийт хөрөнгө	465,139,500	633,252,115	215,306,042	373,613,998	385,503,772	2,072,815,427
Нийт өр төлбөр	574,430,695	339,675,257	127,008,911	874,629,056	23,230,756	1,938,974,675

Доорх хүснэгтэнд Банкны 2013 оны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба тодорхой хөрөнгө, өр төлбөрийн талаарх мэдээллийг толилууллаа.

	Иргэдийн банк 2013 мян.төг	Бизнесийн банк 2013 мян.төг	Орон сууцны Банк 2013 мян.төг	Хөрөнгө зохицуулалтын хэлтэс 2013 мян.төг	Хуваарилаг- даагүй 2013 мян.төг	Нийт 2013 мян.төг
Орлого						
Гуравдагч тал	27,190,350	57,731,724	17,970,325	(11,081,601)	607,219	92,418,017
Сегмент хоорондын	12,934,108	(18,032,086)	(5,855,172)	10,953,150	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	40,124,458	39,699,638	12,115,153	(128,451)	607,219	92,418,017
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(876,143)	(8,667,401)	(137,952)	-	(25,144)	(9,706,640)
Үйл ажиллагааны цэвэр орлого	39,248,315	31,032,237	11,977,201	(128,451)	582,075	82,711,377
Үр дүнгүүд						
Хүүгийн цэвэр орлого (зардал)	25,014,927	54,870,776	17,933,760	(17,129,360)	-	80,690,103
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	2,127,841	2,852,849	36,567	-	-	5,017,257
Арилжааны цэвэр алдагдал	-	-	-	(2,277,076)	-	(2,277,076)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(368,636)	(130,848)	-	(3,913)	(3,207,097)	(3,710,494)
Биет бус хөрөнгийн хорогдол	-	-	-	-	(816,248)	(816,248)

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Иргэдийн банк 2013 мян.төг	Бизнесийн банк 2013 мян.төг	Орон сууцны Банк 2013 мян.төг	Хөрөнгө зохицуулалтын хэлтэс 2013 мян.төг	Хуваарилаг- даагүй 2013 мян.төг	Нийт 2013 мян.төг
Сегментийн ашиг (алдагдал)	34,362,176	29,445,687	11,977,201	(199,226)	(45,693,254)	29,892,584
Орлогын татварын зардал	-	-	-	-	(5,520,275)	(5,520,275)
Тайлант жилийн ашиг	34,362,176	29,445,687	11,977,201	(199,226)	(51,213,529)	24,372,309
Хөрөнгө						
Капитал зардал						
Үндсэн хөрөнгө	-	-	-	-	8,545,288	8,545,288
Бусад биет бус хөрөнгө	-	-	-	-	1,986,179	1,986,179
	-	-	-	-	10,531,467	10,531,467
Нийт хөрөнгө	338,228,619	530,366,530	160,946,144	458,484,858	323,458,441	1,811,484,592
Нийт өр төлбөр	484,833,999	230,444,262	136,983,091	819,990,003	17,028,193	1,689,279,548

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хуваарилагдаагүй орлого ба зардлыг оруулахгүйгээр нийт сегментийн татварын өмнөх ашиг болон Банкны нийт татварын өмнөх ашгийг тохируулан дараах байдлаар үзүүлэв:

	2014 мян.төг	2013 мян.төг
Нийт сегментийн татварын өмнөх ашиг	60,748,060	75,585,838
Байгууллагын боловсон хүчний зардал	(24,980,910)	(24,381,517)
Байгууллагын удирдлагын зардал	(23,775,411)	(21,893,811)
Бусад үйл ажиллагааны орлого	327,096	607,218
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	-	-
Зээл болон бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(110,801)	(25,144)
Дэлгэрэнгүй орлогын тайланд тусгасан татварын өмнөх ашиг	12,208,034	29,892,584

Сегментүүдийн нийт хөрөнгийг Банкны нийт хөрөнгөтэй дараах байдлаар тохируулан үзүүлэв:

	2014 мян.төг	2013 мян.төг
Нийт сегментийн хөрөнгө	1,687,311,655	1,488,026,151
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	187,780,433	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	138,422,940	39,146,611
Бусад хөрөнгө	6,602,101	4,293,565
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	10,727,557	5,105,763
Үндсэн хөрөнгө	31,241,651	29,595,235
Биет бус хөрөнгө	8,407,675	5,666,416
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,321,415	1,035,981
Санхүүгийн байдлын тайланд тусгасан нийт хөрөнгө	2,072,815,427	1,811,484,592

Сегментүүдийн нийт өр төлбөрийг Банкны нийт өр төлбөртэй дараах байдлаар тохируулан үзүүлэв:

	2014 мян.төг	2013 мян.төг
Нийт сегментийн өр төлбөр	1,915,743,919	1,672,251,355
Хойшлогдсон нөхцөлт хандив	1,622,531	1,957,277
Бусад өр төлбөр	21,206,909	13,142,756
Орлогын татварын өглөг	401,316	1,928,160
Санхүүгийн байдлын тайланд тусгасан нийт өр төлбөр	1,938,974,675	1,689,279,548

4. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2014 мян.төг	2013 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	207,475,709	157,344,867
Санхүүгийн хөрөнгө оруулалт- дуусвар хугацаа хүртэл эзэмших	28,694,129	21,627,677
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	1,157,533	1,181,734
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	1,025,186	793,233
Урвуу репо хэлцэл	103,290	74,836
	238,455,847	181,022,347

5. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	2014 мян.төг	2013 мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	74,218,518	55,071,947
Зээлээр авсан санхүүжилт	46,736,416	27,279,114
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	12,760,325	13,251,667
Хоёрдогч өглөг	7,212,805	4,372,635
Репо хэлцэл	118,626	356,881
	141,046,690	100,332,244

6. ХУРААМЖ БА ШИМТГЭЛИЙН ЦЭВЭР ОРЛОГО

	2014 мян.төг	2013 мян.төг
Хураамж ба шимтгэлийн орлого		
Мөнгөн гуйвуулга болон бусад үйлчилгээний хураамж	3,923,064	3,285,223
Картын үйлчилгээний хураамж ба шимтгэл	2,274,754	1,520,475
Дансны үйлчилгээний хураамж ба шимтгэл	943,739	727,600
Зээлийн үйлчилгээний хураамж ба шимтгэл	549,423	266,328
	7,690,980	5,799,626
Хураамж ба шимтгэлийн зардал		
Банкны үйлчилгээний шимтгэл	459,738	449,359
Картын гүйлгээний шимтгэл	559,643	333,010
	1,019,381	782,369
	6,671,599	5,017,257

7. АРИЛЖААНЫ ЦЭВЭР ОРЛОГО

	2014 мян.төг	2013 мян.төг
Гадаад валютын	(85,746)	2,187,248
Өмчийн үнэт цаасны	-	(10,463)
Өрийн үнэт цаасны	139,774	391,509
	54,028	2,568,294

Гадаад валютын ашиг/(алдагдал)-д своп, форвард болон бусад валютын үүсмэл хэрэгслүүдийн хэлцлээс бий болсон ашиг алдагдлууд орно.

Өмчийн үнэт цаасны ашиг/(алдагдал)-д өмчийн үнэт цаасыг худалдан авах, худалдах арилжааны үр дүн болон тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд орно.

Өрийн үнэт цаасны ашигт өрийн үнэт цаасыг худалдан авах, худалдах арилжааны үр дүн болон тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд орно.

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО - ЦЭВЭР

	2014 мян.төг	2013 мян.төг
Арилжааны бус валютын ханшийн зөрүүний (гарз)/олз	(8,201,037)	3,479,466
Түрээсийн орлого	86,896	138,669
Үндсэн хөрөнгө борлуулсны (гарз)/олз	(466)	21,382
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны олз (Тодруулга 20)	61,029	9,819
Бусад	221,457	493,027
	(7,832,121)	4,142,363

9. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДЛЫН ЗАРДАЛ

	2014 мян.төг	2013 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 18)		
Жижиг дунд бизнесийн (ЖДБ) зээл	24,772,728	8,676,065
Орон сууцны зээл	904,538	153,017
Бичил бизнесийн зээл	1,994,532	388,995
Хэрэглээний зээл	996,057	559,541
Санхүүгийн түрээс	307,033	(102,199)
Бусад	801,609	6,077
	29,776,497	9,681,496
Бусад хөрөнгө (Тодруулга 19)	110,801	25,144
	29,887,298	9,706,640

10. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2014 мян.төг	2013 мян.төг
Боловсон хүчний зардлууд*	24,980,910	24,381,517
Мэргэжлийн үйлчилгээний зардал	5,986,084	6,186,215
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 21)	4,255,388	3,710,494
Зар сурталчилгаа	2,318,285	3,465,908
Түрээс	4,630,001	3,273,717
Хадгаламжийн даатгалын зардал	1,916,535	1,910,682
Харуул хамгаалалтын зардал	2,010,998	1,859,445
Харилцаа холбооны зардал	1,438,882	1,308,366
Хүлээн авалтын зардал	785,399	1,261,069
Бусад үйл ажиллагааны зардал	1,132,441	1,932,759
Биет бус хөрөнгийн хорогдол (Тодруулга 22)	986,182	816,248
Тээврийн зардал	677,307	786,954
Албан томилолтын зардал	763,036	714,995
Бичиг хэргийн зардал	855,125	695,697
Ашиглалтын зардал	596,893	536,313
Урсгал засварын зардал	416,558	427,234
Гишүүнчлэл ба аудитын зардал	276,346	352,207
Даатгалын зардал	298,447	259,566
Хандивын зардал	72,949	123,494
Торгууль	11,149	59,105
Зээл цуглуулалтын зардал	36,920	49,359
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал (Тодруулга 19)	418,496	31,314
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 21)	246,878	69
	55,111,209	54,142,727
* Боловсон хүчний зардлууд		
Цалин, хөлс болон урамшуулал	21,697,627	21,460,158
Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл	2,574,625	2,170,986
Тэтгэврийн тогтоосон төлөвлөгөөний дагуу хийсэн хуримтлалын хорогдуулга	643,528	665,024
Ажилчдын сургалт	65,130	85,349
	24,980,910	24,381,517

11. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

2014 болон 2013 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон тайлант жилүүдийн орлогын татварын зардлын бүрэлдэхүүнд:

	2014 мян.төг	2013 мян.төг
Тайлант жилийн татвар:		
Тайлант жилийн орлогын татвар	1,857,760	5,871,956
Хойшлогдсон татвар:		
Түр зөрүүгийн үүсэл болон буцаалттай холбогдуулан (Тэмдэглэл 23)	(1,285,434)	(351,681)
	572,326	5,520,275

11. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк нь санхүүгийн тайланд орлогын татварын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 3 тэрбум (2013 онд 3 тэрбум) төгрөг хүртэл ашгаас 10% (2013 онд 10%)-ийн, 3 тэрбумаас (2013 онд 3 тэрбум) дээш төгрөгийн ашгаас 25% (2013 онд 25%)-ийн орлогын татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүгийн орлогод татвар тооцдоггүй. Зээл ба урьдчилгаанд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулга нь татвар ногдох орлогоос хасагдах зардал болдог.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2014 мян.төг	2013 мян.төг
Татварын өмнөх ашиг	12,208,034	29,892,584
25 %-ийн орлогын татвар (2013 онд 25%)	3,052,009	7,473,146
Бага хувийн татвар ногдох орлогын нөлөө	(450,000)	(450,000)
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(3,969,949)	(1,575,068)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	1,940,266	72,197
Тайлант жилийн татварын зардал	572,326	5,520,275

2014 онд үр ашигт орлогын татварын хувь хэмжээ 4.69% (2013 онд 18.37%) байсан.

12. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Доорх хүснэгтээр нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд ашигласан орлого болон хувьцааны мэдээллийг үзүүлэв:

	2014 мян.төг	2013 мян.төг
Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох, нийт дэлгэрэнгүй орлого (татварын дараах)	11,635,708	24,372,309

	2014	2013
Нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд хэрэглэгдэх энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо	20,353,656	20,353,656

	2014 төгрөгөөр	2013 Төгрөгөөр
Тайлант жилд банкны хувьцаа эзэмшигчдийн: Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	571.68	1,197.44

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

	Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	571.68	1,197.44
12.	НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ (ҮРГЭЛЖЛЭЛ)		

Тайлагналын өдрөөс авахуулаад эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэж дуусах хүртэл нэгж хувьцаанд ногдох ашгийг дахин тайлагнахыг шаардах энгийн хувьцаа болон боломжит энгийн хувьцаатай холбоотой ажил гүйлгээ гараагүй болно.

13. БЭЛЭН МӨНГӨ БА МОНГОЛБАНКИН ДАХЬ ХАРИЛЦАХ

	2014 мян.төг	2013 мян.төг
Монголбанкин дахь харилцах	145,990,603	202,049,732
Бэлэн мөнгө	41,789,830	36,565,138
	187,780,433	238,614,870

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах үлдэгдэл нь хоёр долоо хоногийн турш дахь харилцагчдын харилцах, хадгаламжийн дундаж үлдэгдлийн 12.0% (2013: 12.0%)-иас багагүй байдаг. 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр 87,457.48 сая төгрөг (2013: 71,715.80 сая төгрөг) ба гадаад валютаар 23,110.78 сая төгрөг (2013: 17,768.70 сая төгрөг) байсан.

14. БУСАД БАНК БА САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2014 мян.төг	2013 мян.төг
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	138,422,940	121,851,611

Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж нь дотоодын болон гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан дотоод болон гадаад валютын харилцах болон хадгаламжийн дансыг хэлнэ.

15. УРВУУ РЕПО ХЭЛЦЭЛ

	2014 мян.төг	2013 мян.төг
Урвуу репо хэлцэл	152,799,124	29,991,255

Урвуу репо хэлцлийн дагуу Банк нь Монголбанкны үнэт цаасыг тодорхой заасан ирээдүйн өдөр буцаан борлуулах нөхцөлтэй худалдан авсан. Үнэт цаас нь 2 хоногийн хугацаатай, бодит үнэ цэнэ нь 2014 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнэтэйгээ ойролцоо байсан.

16. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮД

Доорх хүснэгтэнд хөрөнгө болон өр төлбөрөөр бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийг хамтаар харууллаа. Нийт дүнгээрээ бүртгэгдсэн нэрлэсэн үнэ нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсвэл индекс байх бөгөөд санхүүгийн үүсмэл хэрэгслийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсвэл зээлийн эрсдлийн аль алинийг нь тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

	Хөрөнгө 2014 мян.төг	Өр төлбөр 2014 мян.төг	Нэрлэсэн үнэ 2014 мян.төг
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэгслүүд			
Валютын своп хэлцэл	1,469,087	2,427,739	341,293,600
	1,469,087	2,427,739	341,293,600
	2013 мян.төг	2013 мян.төг	2013 мян.төг
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэгслүүд			
Валютын форвард хэлцэл	596,833	626,804	1,109,074
Валютын своп хэлцэл	40,002	-	1,109,074
	636,835	626,804	2,218,148

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсвэл огт шаардагдахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байна. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний жижиг хэмжээний өөрчлөлт нь ч банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Банк нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдлийн удирдлагын хүрээнд тодорхойлдог. (Тодруулга 39.4-г үзнэ үү).

Форвард хэлцлүүд

Форвард хэлцлүүд нь санхүүгийн хэрэглүүрийг ирээдүйн тодорхой нэгэн цагт, тогтоосон үнээр нэг тал нь худалдан авч, нөгөө тал нь худалдах тухай үүрэг хүлээсэн гэрээнүүд юм. Форвардыг лангууны арын зах зээлд гэрээний дагуу арилжаална.

Своп хэлцлүүд

Ирээдүйн тодорхой нэгэн үед хэлцлийн хоёр талын оролцогчийн хооронд хүүгийн түвшин, гадаад валютын ханшийн түвшин эсвэл хувьцааны индекс зэргийг суурь болгон төлбөр солилцох зорилготой тохиролцоо юм.

Валютын своп хэлцлийн үед банк нь тодорхой хэмжээний валютыг худалдаж, оронд нь мөн тохиролцсон хэмжээний өөр нэг валютыг хүлээн авна. Валютын своп тус бүр бие даасан гэрээгээр зохицуулагдана.

16. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнэ

Тодруулга 35-д санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн тодруулгыг оруулсан.

17. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2014 мян.төг	2013 мян.төг
Борлуулахад бэлэн:		
Тогтмол орлоготой хөрөнгө оруулалт		
Ипотекийн зээлээр баталгаажсан давуу эрхтэй бонд (“ИЗББ”), бодит үнэ цэнээр	-	13,250,686
Ипотекийн зээлээр баталгаажсан энгийн бонд (“ИЗББ”), бодит үнэ цэнээр	6,929,591	1,474,508
	6,929,591	14,725,194
Өмчийн үнэт цаас		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өмчийн үнэт цаас, өртгөөр	821,800	775,500
	7,751,391	15,500,694
Дуусвар хугацаа хүртэл эзэмших:		
Монголбанкны үнэт цаас, хорогдуулсан өртгөөр	79,862,222	224,745,335
Засгийн газрын үнэт цаас, хорогдуулсан өртгөөр	116,442,440	89,661,748
Засгийн газрын бонд, хорогдуулсан өртгөөр	15,289,735	15,175,733
	211,594,397	329,582,816

Энгийн болон давуу эрхтэй “ИЗББ” нь Монголын Ипотекийн Корпорациас (“МИК”) гаргасан хүү тооцдог, урт хугацаат үнэт цаас юм (Тодруулга 18-г үзнэ үү).

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өмчийн үнэт цаас нь хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компанид оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй учир тэдгээрийг өртгөөр нь бүртгэдэг. Үнэлгээний техникүүдийг ашиглан хийсэн бодит үнэ цэнийн тооцооллууд хоорондоо их хэмжээгээр зөрнө гэсэн хүлээлттэй байна. Энэ хөрөнгө оруулалтын хувьд зах зээл байхгүй ба Банк энэхүү хөрөнгө оруулалтыг ойрын ирээдүйд зарж борлуулах төлөвлөгөөгүй байна.

Монголбанкны болон Засгийн газрын үнэт цаас нь богино хугацаатай, хүү тооцдог, хөнгөлөлттэй гаргасан үнэт цаас юм.

Засгийн газрын бонд нь урт хугацаатай, хүү тооцдог, хөнгөлөлттэй гаргасан үнэт цаас юм.

18. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

	2014 мян.төг	2013 мян.төг
ЖДБ-ийн зээл	666,672,078	541,851,743
Орон сууцны зээл	227,531,527	180,158,347
Бичил бизнесийн зээл	217,069,051	150,561,456
Хэрэглээний зээл	108,339,617	100,956,245
Санхүүгийн түрээс	30,985,839	22,992,426
Бусад	94,675,716	40,221,477
	1,345,273,828	1,036,741,694
Хуримтлагдсан хүүгийн авлага	16,545,076	11,268,515
Нийт зээл ба урьдчилгаа	1,361,818,904	1,048,010,209
Хасах нь: Үнэ цэнэ бууралтын хасагдуулга	(48,121,248)	(18,468,915)
Цэвэр зээл ба урьдчилгаа	1,313,697,656	1,029,541,294

Бүхэлд нь үл хүлээн зөвшөөрч бусдад шилжүүлсэн санхүүгийн хөрөнгүүд

Банк нь 2014 оны 7-р сарын 8 болон 2014 оны 11-р сарын 6-ны өдрүүдэд тогтмол хүүтэй барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг 100% авах эрхийг МИК-ийн эзэмшлийн тусгай зориулалтын компанид худалдаж, оронд нь ИЗББ-ыг худалдан авсан. Банк нь санхүүгийн тайланд зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрсөн ба давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн. Банк эдгээр зээлүүдтэй холбоотой үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлсээр байгаа учир МИК-ээс 2.5%-ийн үйлчилгээний шимтгэл авдаг. Шилжүүлсэн өдрөөрх зээлийн багцын дансны үнэ нь 52,973 сая төгрөг байсан. Санхүүгийн тайланд давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг 47,676 сая төгрөг болон 5,297 сая төгрөгөөр тус тус хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 17).

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын хасагдуулга

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын хасагдуулгын тохируулгыг зээлийн анги тус бүрээр нь салган үзүүлбэл:

	ЖДБ мян.төг	Орон сууцны мян.төг	Бичил бизнес мян.төг	Хэрэглээ мян.төг	Санхүүгийн Түрээс мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2014 оны 12 дугаар сарын 31-нээр							
2014 оны 1 дүгээр сарын 1-нээр	15,841,586	651,405	812,787	880,065	204,249	78,824	18,468,916
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	28,844,157	1,176,711	2,312,248	1,407,654	374,401	833,836	34,949,007
Эргэн төлөлт (Тодруулга 9)	(4,071,429)	(272,173)	(317,716)	(411,597)	(67,368)	(32,227)	(5,172,510)
Данснаас хассан	(2)	(11,222)	(56,162)	(39,859)	(5,710)	(11,210)	(124,165)
2014 оны 12 дугаар сарын 31-ээр	40,614,312	1,544,721	2,751,157	1,836,263	505,572	869,223	48,121,248
Тусдаа үнэ цэнэ нь буурсан	14,590,596	-	-	-	-	-	14,590,596
Багцаараа үнэ цэнэ нь буурсан	26,023,716	1,544,721	2,751,157	1,836,263	505,572	869,223	33,530,652
	40,614,312	1,544,721	2,751,157	1,836,263	505,572	869,223	48,121,248
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай гарсан зээлийн тусгай үнэ цэнийн бууралтын дүнг хасахаас өмнөх нийт дүн	23,648,847	-	-	-	-	-	23,648,847

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын хасагдуулга (Үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын хасагдуулгын тохируулгыг зээлийн анги тус бүрээр нь салган үзүүлбэл:

	ЖДБ мян.төг	Орон сууцны мян.төг	Бичил бизнес мян.төг	Хэрэглээ мян.төг	Санхүүгийн Түрээс мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2013 оны 12 дугаар сарын 31-нээр							
2013 оны 1 дүгээр сарын 1-нээр	7,165,521	501,501	466,697	384,665	337,110	72,747	8,928,241
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	12,716,496	486,221	598,110	674,616	71,843	29,676	14,576,962
Эргэн төлөлт (Тодруулга 9)	(4,040,431)	(333,204)	(209,115)	(115,075)	(174,042)	(23,599)	(4,895,466)
Данснаас хассан	-	(3,113)	(42,905)	(64,141)	(30,663)	-	(140,822)
2013 оны 12 дугаар сарын 31-ээр	15,841,586	651,405	812,787	880,065	204,248	78,824	18,468,915
Тусдаа үнэ цэнэ нь буурсан	10,967,927	-	-	-	1,011	-	10,968,938
Багцаараа үнэ цэнэ нь буурсан	4,873,659	651,405	812,787	880,065	203,237	78,824	7,499,977
	15,841,586	651,405	812,787	880,065	204,248	78,824	18,468,915
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай гарсан зээлийн тусгай үнэ цэнийн бууралтын дүнг хасахаас өмнөх нийт дүн	17,090,777	-	-	-	18,350	-	17,109,127

18. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Тусдаа үнэ цэнийн бууралтанд орсон Банкны эзэмшиж буй зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 2014 оны 12-р сарын 31-ний байдлаар 23,911 сая төгрөг (2013 онд 11,742 сая төгрөг) байна. Эдгээр үнэлгээг удирдлагаас хамгийн сүүлийн үеийн боломжит мэдээлэлд үндэслэн гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 39 "Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд" хэсгээс үзнэ үү.

Банк нь 2014 онд гадны санхүүгийн байгууллагатай хамтран, хамтын санхүүжилтийн зээл олгосон ба ийнхүү олгосон зээлийг ЖДБ-ийн зээлд бүртгэсэн. Банк нь хамтын санхүүжилтийн зээлийн зохион байгуулагч банкаар оролцож, зээлийн 50 хувийг санхүүжүүлсэн.

19. БУСАД ХӨРӨНГӨ

	2014 мян.төг	2013 мян.төг
Бусад хөрөнгө	1,517,977	1,224,494
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(139,084)	(49,484)
	1,378,893	1,175,010
Хураан авсан хөрөнгө	1,271,234	328,143
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(505,694)	(87,198)
	765,540	240,945
Хангамж ба бусад бараа материал	1,289,142	1,249,561
Урьдчилж төлсөн зардал	2,462,894	1,450,274
Барьцаа	612,504	152,904
Үнэт металл	93,128	93,128
	4,457,668	2,945,867
Нийт бусад хөрөнгө	6,602,101	4,361,822
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулга		
1-р сарын 1-нээр	49,484	33,544
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	110,801	25,144
Данснаас хассан	(21,201)	(9,204)
12-р сарын 31-нээр	139,084	49,484
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулга		
1-р сарын 1-нээр	87,198	55,884
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 10)	2,204,565	56,035
Эргэн төлөлт (Тодруулга 10)	(1,786,069)	(24,721)
Данснаас хассан	-	-
12-р сарын 31-нээр	505,694	87,198

20. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ХӨРӨНГӨ

Банкны борлуулсан эсвэл борлуулах үе шатандаа явж байгаа болон хураан авсан хөрөнгүүд дараах байдалтай байна:

	2014 мян.төг	2013 мян.төг
1-р сарын 1-нээр	5,105,763	1,031,577
Нэмэх нь: борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	6,354,292	4,197,351
рүү нэмж ангилсан хураан авсан хөрөнгүүд		
Хасах нь: жилийн туршид худалдан борлуулсан	(732,498)	(123,165)
12-р сарын 31-нээр	10,727,557	5,105,763

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөөс жилийн туршид 811 сая төгрөг (2013: 133 сая төгрөг)-ийн хөрөнгийг борлуулсан бөгөөд эдгээрийг борлуулсны олз болох 61.0 сая төгрөг (2013: 9.8 сая төгрөг)-ийг ‘Үйл ажиллагааны бусад орлого’ (Тодруулга 8) хэсэгт тайлагнасан.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

21. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Түрээсийн хөрөнгийн сайжруулалт	Барилга байшин	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер, тоног төхөөрөмж	Ашиглах зорилгоор эзэмшиж буй газар	Дуусаагүй барилга	Нийт
2014 оны 12-р сарын 31	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Өртгөөр								
2014 оны 1-р сарын 1-нээр	1,690,075	14,917,348	3,261,645	3,249,486	17,272,699	2,091,896	330,864	42,814,013
Нэмэгдсэн	902,732	113,287	716,813	295,002	2,906,392	-	1,572,773	6,506,999
Данснаас хассан	(464,703)	(96,529)	-	(157,874)	(719,746)	-	-	(1,438,852)
Худалдан борлуулсан	-	(157,419)	(189,494)	(109,692)	(179,522)	-	(119,062)	(755,189)
Дахин ангилсан	-	96,938	-	467,102	-	118,896	(694,040)	(11,104)
2014 оны 12-р сарын 31- нээр	2,128,104	14,873,625	3,788,964	3,744,024	19,279,823	2,210,792	1,090,535	47,115,867
Хуримтлагдсан элэгдэл								
2014 оны 1-р сарын 1-нээр	993,865	1,725,119	1,137,652	1,255,391	8,106,751	-	-	13,218,778
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 10)	339,636	453,342	365,291	320,381	2,776,738	-	-	4,255,388
Данснаас хассан	(270,149)	(96,528)	-	(105,941)	(719,356)	-	-	(1,191,974)
Худалдан борлуулсан	-	(36,047)	(129,349)	(58,172)	(173,304)	-	-	(396,872)
Дахин ангилсан	-	(11,104)	-	-	-	-	-	(11,104)
2014 оны 12-р сарын 31- нээр	1,063,352	2,034,782	1,373,594	1,411,659	9,990,829	-	-	15,874,216
2014 оны 12-р сарын 31- нээрх дансны үнэ	1,064,752	12,838,843	2,415,370	2,332,365	9,288,994	2,210,792	1,090,535	31,241,651

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

21. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Түрээсийн хөрөнгийн сайжруулалт	Барилга байшин	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Компьютер, тоног төхөөрөмж	Ашиглах зорилгоор эзэмшиж буй газар	Дуусаагүй барилга	Нийт
2013 оны 12-р сарын 31	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Өртгөөр								
2013 оны 1-р сарын 1-нээр	1,583,933	12,699,028	3,180,180	3,067,503	12,910,034	-	1,615,334	35,056,012
Нэмэгдсэн	48,724	95,258	271,078	250,756	4,669,743	2,091,896	1,117,833	8,545,288
Данснаас хассан	-	(2,083)	(96,671)	(18,587)	(166,623)	-	(65)	(284,029)
Худалдан борлуулсан	-	(167,900)	(92,942)	(54,018)	(160,707)	-	(27,691)	(503,258)
Дахин ангилсан	57,418	2,293,045	-	3,832	20,252	-	(2,374,547)	-
2013 оны 12-р сарын 31-нээр	<u>1,690,075</u>	<u>14,917,348</u>	<u>3,261,645</u>	<u>3,249,486</u>	<u>17,272,699</u>	<u>2,091,896</u>	<u>330,864</u>	<u>42,814,013</u>
Хуримтлагдсан элэгдэл								
2013 оны 1-р сарын 1-нээр	644,283	1,391,422	992,567	1,013,635	6,021,787	-	-	10,063,694
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 10)	349,582	338,227	308,258	298,345	2,416,082	-	-	3,710,494
Данснаас хассан	-	(2,081)	(96,671)	(12,471)	(172,737)	-	-	(283,960)
Худалдан борлуулсан	-	(2,449)	(66,502)	(44,118)	(158,381)	-	-	(271,450)
2013 оны 12-р сарын 31-нээр	<u>993,865</u>	<u>1,725,119</u>	<u>1,137,652</u>	<u>1,255,391</u>	<u>8,106,751</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>13,218,778</u>
2013 оны 12-р сарын 31- нээрх дансны үнэ	<u>696,210</u>	<u>13,192,229</u>	<u>2,123,993</u>	<u>1,994,095</u>	<u>9,165,948</u>	<u>2,091,896</u>	<u>330,864</u>	<u>29,595,235</u>

22. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Патент ба эрх мян.төг	Программ хангамж мян.төг	Дуусаагүй программ хангамж мян.төг	Нийт мян.төг
2014 оны 12-р сарын 31				
Өртгөөр				
1-р сарын 1-нээр	131,433	6,782,171	1,334,192	8,247,796
Нэмэгдсэн	355,251	1,064,672	2,951,963	4,371,886
Данснаас хассан	(218,430)	(97,800)	(641,981)	(958,211)
Дахин ангилсан	3,182,339	(862,550)	(2,921,768)	(601,979)
12-р сарын 31-нээр	<u>3,450,593</u>	<u>6,886,493</u>	<u>722,406</u>	<u>11,059,492</u>
Хуримтлагдсан хорогдол				
1-р сарын 1-нээр	54,158	2,527,222	-	2,581,380
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 10)	381,712	604,470	-	986,182
Данснаас хассан	(217,896)	(95,870)	-	(313,766)
Дахин ангилсан	680,316	(1,282,295)	-	(601,979)
12-р сарын 31-нээр	<u>898,290</u>	<u>1,753,527</u>	<u>-</u>	<u>2,651,817</u>
Дансны үнэ	<u>2,552,303</u>	<u>5,132,966</u>	<u>722,406</u>	<u>8,407,675</u>
2013 оны 12-р сарын 31				
Өртгөөр				
1-р сарын 1-нээр	115,394	6,057,348	91,100	6,263,842
Нэмэгдсэн	18,264	724,823	1,243,092	1,986,179
Худалдан борлуулсан	(2,225)	-	-	(2,225)
12-р сарын 31-нээр	<u>131,433</u>	<u>6,782,171</u>	<u>1,334,192</u>	<u>8,247,796</u>
Хуримтлагдсан хорогдол				
1-р сарын 1-нээр	43,942	1,721,332	-	1,765,274
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 10)	10,358	805,890	-	816,248
Худалдан борлуулсан	(142)	-	-	(142)
12-р сарын 31-нээр	<u>54,158</u>	<u>2,527,222</u>	<u>-</u>	<u>2,581,380</u>
Дансны үнэ	<u>77,275</u>	<u>4,254,949</u>	<u>1,334,192</u>	<u>5,666,416</u>

23. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ

	2014 мян.төг	2013 мян.төг	
1-р сарын 1-ний өдрөөр	1,035,981	684,300	
Дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 11)	1,285,434	351,681	
12-р сарын 31-ний өдрөөр	2,321,415	1,035,981	
	Хойшлогдсон татварын өр төлбөр	Хойшлогдсон татварын хөрөнгө	Цэвэр хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)
	мян.төг	мян.төг	мян.төг
2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр			
Үндсэн хөрөнгө			
- Түргэвчилсэн татварын элэгдэл	449,878	-	(449,878)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа			
-Хойшлогдсон зээл олголтын хураамж	-	1,419,807	1,419,807
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд			
-Свопын дахин үнэлгээ	-	1,351,486	1,351,486
	449,878	2,771,293	2,321,415
2013 оны 12-р сарын 31-ний өдрөөр			
Үндсэн хөрөнгө			
- Түргэвчилсэн татварын элэгдэл	(322,492)	-	(322,492)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа			
-Хойшлогдсон зээл олголтын хураамж	-	1,358,473	1,358,473
	(322,492)	1,358,472	1,035,981

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24. БУСАД БАНК БА САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙРШУУЛСАН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2014 мян.төг	2013 мян.төг
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	<u>34,317,691</u>	<u>141,706,978</u>

25. РЕПО ХЭЛЦЭЛ

	2014 мян.төг	2013 мян.төг
Репо хэлцэл	<u>179,763,676</u>	<u>162,428,300</u>

Репо хэлцлийн дагуу Банк нь Монголбанкны үнэт цаасыг ирээдүйд буцаан худалдан авах нөхцөлтэй борлуулсан. Үнэт цаас нь 2 хоногийн хугацаатай, зах зээлийн үнэ нь 2014 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дансны үнэтэйгээ ойролцоо байсан.

26. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2014 мян.төг	2013 мян.төг
Засгийн газрын:		
- Харилцах данс	4,279,431	1,420,139
- Хугацаагүй хадгаламж	537,795	913
Хувийн секторын:		
- Харилцах данс	81,369,132	78,415,377
- Хугацаагүй хадгаламж	31,524,892	20,977,697
- Хугацаатай хадгаламж	104,630,957	57,573,967
Иргэдийн:		
- Харилцах данс	16,763,330	10,265,726
- Хугацаагүй хадгаламж	116,161,964	111,788,573
- Хугацаатай хадгаламж	442,481,512	364,040,791
	<u>797,749,013</u>	<u>644,483,183</u>

Харилцагчдын харилцах, хадгаламжинд банкнаас гаргаж буй үл цуцлах санхүүгийн баталгаанд барьцаа хөрөнгө болгож байршуулсан 8,718 сая (2013: 8,771 сая төгрөг) төгрөгийн хадгаламж багтаж байна.

27. ЗЭЭЛЭЭР АВСАН САНХҮҮЖИЛТ

	2014 мян.төг	2013 мян.төг
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан санхүүжилтүүд		
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (“ЕСБХБ”)	69,649,344	49,916,201
Азийн Хөгжлийн Банк	56,045,929	-
Майкрофайнанс Энхансмент Фасилити ЭсЭй СИКАВ	47,856,073	33,635,470
Олон Улсын Хөгжлийн ОПЕК Сан	37,269,192	-
Недарландын Хөгжил Санхүүжилтийн Компани	36,110,652	9,192,435
Австрийн Хөгжлийн Банк	28,543,013	-
Социете Де Промоушн Эт Дэ Партишипэйшн Поур Ла Ко- оперэйшн Экономик ЭсЭй	28,363,662	24,771,289
Дойчи Инвестишнз- Унд Энтвиклангсгеселлшафт ЭмБиЭйч	28,186,167	32,845,067
Глобал Клаймет Нөхөрлөлийн Сан ЭсЭй СИКАВ	28,139,170	24,625,039
Кредит Свисс Майкрофайнанс Менежмент Компани	24,686,080	24,979,728
Бичил, Жижиг Дунд Бизнесийн Бонд ЭсЭй	18,396,177	16,118,897
Ойкокредит, Эдийн Засгийн Хөгжлийн Хамтарсан Нийгэмлэг	14,006,811	19,788,147
Триодос Фэйр Шэйр Сан	11,962,985	10,983,834
Триодос Сикав II – Триодос Майкрофайнанс Фандз	11,962,985	11,097,941
Банк Им Бистум Эссэн ИЖи	11,393,609	-
РеспонсАбилити СИКАВ (Люкс) Майкрофайнанз Фандз	11,382,843	10,814,298
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк	10,030,526	13,084,623
Калверт Соушл Инвестмент Фаундэйшн, Инк.	9,666,637	-
Нидерландын Олон Улсын Групп	9,094,640	7,895,362
ВиДиКэй Спаарбанк	7,704,086	8,333,673
Капитал Гестион – Майкрофайнанс	7,573,517	6,625,913
Азийн Бичил Санхүүжилтийн Эхлэл Зээлийн Сан	7,139,360	8,307,215
КэйСиДи Майкрофайнанзфондз	5,717,139	5,015,231
ЭСИБи Бичил Санхүүжилтийн сан	5,205,450	5,181,402
Гуевоура Сан	4,698,621	-
Кредитансталт фуер Виедеранфбау	3,403,570	2,894,906
РеспонсАбилити СИКАВ (Люкс) Санхүүжилтийн Сан	2,840,951	2,492,005
Финетик Бичил Санхүүжилт	1,941,652	1,698,416
РеспонсАбилити СИКАВ (Люкс) Майкрофайнанз Лидерз	1,908,070	2,503,664
Уолберг Инвест ЭсЭй	1,891,604	1,654,502
Дуэл Ретурн Фанд СИКАВ	1,791,159	3,073,722
КИВА	1,135,809	1,560,564

27. ЗЭЭЛЭЭР АВСАН САНХҮҮЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2014 мян.төг	2013 мян.төг
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан санхүүжилтүүд (үргэлжлэл)		
Эмэржинг Сустенабл Фандз	684,526	681,178
РосЕвроБанк	-	18,221,666
Глобал Майкрофайнанс Фасилити	-	16,754,956
ЭсЭнЭс АйЭмЭф/Трипл Жамп	-	7,616,781
ЭйЭсЭн-Новиб Фандз	-	4,151,933
Сумитомо Мицүй Банк	-	3,894,463
Атлантик Форфайтиерангс ЭйЖи	-	563,135
Виттана	-	52,132
Триодос Фэйр Шэйр Сан	-	1,710,939
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан нийт санхүүжилт	546,382,009	392,736,727
Засгийн газар, төрийн байгууллагуудаас авсан санхүүжилт		
Монголбанк	142,768,473	207,801,244
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	83,694,687	27,600,378
Сангийн Яам	9,860,021	11,292,746
Сангийн Яам/Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк	12,394,584	10,852,627
Азийн Хөгжлийн Банк	2,248,857	4,050,048
Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр	2,073,412	2,728,280
Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сан	2,476,077	2,470,907
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан – Улаанбаатар хот	1,080,335	2,082,489
Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан	503,124	1,508,938
Засгийн газар, төрийн байгууллагуудаас авсан нийт санхүүжилт	257,099,570	270,387,657
Бусад компаниудаас авсан санхүүжилт		
Оюу Толгой ХХК	78,879	1,243,820
Зээлээр авсан санхүүжилтийн нийт дүн	803,560,458	664,368,204

Засгийн газар, төрийн байгууллагаас авсан, дээр дурдсан бүх санхүүжилтүүд нь Монгол Улсын Засгийн газартай холбоотой болно.

27. ЗЭЭЛЭЭР АВСАН САНХҮҮЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк нь тайлант хугацааны туршид өр төлбөрөө хугацаанаас нь өмнө урьдчилан төлөөгүй (2013: Тэг). 2014 болон 2013 оны туршид Банк үндсэн болон хүүгийн өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан.

Зээлийн гэрээнүүдийн ихэнх нь тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байхыг банкнаас шаарддаг ба тус нөхцөлүүдийг дараах төрлүүдэд ангилан үзүүлж болно:

- Өөрийн хөрөнгийн харьцаа (эрсдлээр жинлэсэн өөрийн хөрөнгийн харьцаа, төлбөрийн чадварын харьцаа, 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа)
- Санхүүгийн эрсдлийн харьцаанууд (актив, пассивын төлөгдөх хугацааны харьцаа, гадаад валютын эрсдлийн харьцаа, нийт гадаад валютын нээлттэй позиц, нэг гадаад валютын арилжааны эрсдлийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, нийт хүүгийн эрсдлийн харьцаа);
- Зээлийн эрсдлийн харьцаанууд (Эрсдэлтэй зээлийн багцын эрсдэл, шугаман зээлийн эрсдлийн харьцаа, алдагдлаар хаасан зээлийн харьцаа, том зээлдэгч болон өөрийн хөрөнгийн харьцаа, холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа, нийт том зээлдэгчдийн эрсдлийн харьцаа);
- Бусад харьцаанууд (Хадгаламж зээлийн харьцаа, хүү төлөх чадварын эрсдэл, үндсэн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа, үндсэн хөрөнгө, өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын харьцаа, үйл ажиллагааны зардал болон ашгийн харьцаа гэх мэт.).

Биелүүлсэн байх шаардлагатай харьцаануудыг хангаагүй тохиолдолд холбогдох зээлийн үүрэг биелэгдээгүйд тооцогдох буюу зээл нь нэхэмжилсэн үед төлөгдөх шаардлагатай болно. Тиймээс харьцаануудын биелэлтэнд холбогдох хэлтэс, ажилтнууд (санхүү, бүртгэлийн газар, санхүү эрхэлсэн захирал, мөн эрсдлийн нэгдсэн удирдлагын газар, хөрөнгө зохицуулалтын газар, зээлийн удирдлагын газар г.м.) улирал тутамд хяналт тавин ажилладаг. Тодорхой харьцааны биелэлт хангагдахгүйг урьдчилан мэдсэн буюу олж илрүүлсэн тохиолдолд удирдлага нь шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хангах үүргээс түр чөлөөлөгдөх хүсэлт гаргах, харьцааг өөрчлөн гэрээг шинээр байгуулах зэрэг зохистой арга хэмжээг авдаг.

2014 оны 12-р сарын 31-ний байдлаар, Банк нь 28,319 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий нэг том зээлээс бусад бүх л зээлүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлсэн. Уг зээлийн хувьд Банкны удирдлага 2015 оны 9-р сарын 30-ний өдөр хүртэл шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хойшлуулах зөвшөөрөл авсан байгаа.

28. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

	2014 мян.төг	2013 мян.төг
Нидерландын Хөгжлийн Санхүүжилтийн Компани	-	25,098,919
Олон Улсын Санхүүгийн Корпораци	84,842,434	22,328,823
КэйЭфДаблю, Франкфурт ам Майн	7,407,671	6,242,365
Инкофин Импульс Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан	5,675,237	4,967,779
	97,925,342	58,637,886

Олон Улсын Санхүүгийн Корпорациас авсан хоёрдогч өглөг

- (i) 2010 оны 6-р сарын 30-нд Олон Улсын Санхүүгийн Корпорациас 5,000,000 ам.долларын хөрвөх эрхтэй хоёрдогч зээл авсан ба уг зээл нь 2018 оны 12-р сарын 15-нд эргэн төлөгдөх нөхцөлтэй. Үүний дагуу хувьцаанд хөрвүүлэх сонголтыг зөвхөн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрсөн бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарим хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн давуу эрхээ эдлэхээс татгалзсан тохиолдолд хийж болно. Энэ нөхцөлд Олон Улсын Санхүүгийн Корпораци нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үлдэгдэл хувьцааг өмнөх хувьцаа эзэмшигчдэд санал болгосон үнэтэй ижил үнээр худалдан авах эрхтэй. Олон Улсын Санхүүгийн Корпораци нь хувьцааг бэлэн мөнгөөр худалдан авах эсвэл хоёрдогч өглөгийн үлдэгдлийг эргүүлэн төлөх хүсэлтээ Банкинд гаргах замаар хувьцааг худалдан авах эрхтэй.

Хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн үед Олон Улсын Санхүүгийн Корпорацийн шинээр эзэмших хувьцаа нь бүрэн саналын эрхтэй энгийн хувьцаа байх бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн бусад бүх хувьцаатай тэнцүү эрхтэй байна. Уг хувьцааны нийт хэмжээ нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн нийт хувьцаат капиталын 20%-иас илүү байж болохгүй.

Банк нь банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө алдах, төлбөрийн чадвараа алдах, татан буугдах, бүтцийн зохион байгуулалтад орох болон Монголбанкнаас зөвшөөрөл авснаас бусад бүх тохиолдолд зээлийг хугацаа дуусахаас нь өмнө эргэн төлж болохгүй.

Тус зээлийн жилийн хүү нь 6 сарын Лайбор + 6.5 хувийн хувьсах хүүтэй юм. 2014 оны 12-р сарын 31- нээрх үр ашигт хүү жилийн 6.839% (2013 онд 6.915%) байсан. Банк татан буугдах тохиолдолд тус өглөг нь бусад бүх зээлдүүлэгчдийн өр төлөгдсөний дараагаар төлөгдөнө.

28. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Олон Улсын Санхүүгийн Корпорациас авсан хоёрдогч өглөг (үргэлжлэл)

- (ii) 2012 оны 6-р сард Банк нь ОУСК-тай 40,000,000 ам.долларын хоёрдогч зээлийн гэрээнд гарын үсэг зурсан. Банк нь энэ зээлийг 2 салгаж хүлээж авах юм: 9,000,000 ам.долларыг 2012 оны 12-р сард жилийн 8.955%-ийн тогтмол хүүтэйгээр, 31,000,000 ам.долларыг 2014 онд 6 сарын Лайбор + 7.4% (2014: 7.72%)-ийн жилийн хүүтэйгээр. Уг хоёрдогч өглөг нь 2020 оны 12-р сард эргэн төлөгдөх нөхцөлтэй.

КэйЭфДаблю, Франкфурт ам Майнаас авсан хөрвөх нөхцөлтэй хоёрдогч өглөг

Банк нь КэйЭфДаблюгаас 1,800,000 евротой тэнцэх 2,747,230 ам.долларын, хөрвөх нөхцөлтэй, арван жилийн хугацаатай хоёрдогч өглөгийг авсан. Зээлийн хүүгийн дээд хязгаар жилийн 9% байна. Тайлант жилд тус зээлийн үр ашигт хүү нь жилийн 5.688% (2013 онд 5.844%) байна.

Хөрвөх эрхтэй хоёрдогч зээлийг 2017 оны 7-р сарын 20-нд бэлэн мөнгөөр бүхэлд нь эргэн төлөх эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу Банкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа руу хөрвүүлж болно. Хувьцаанд хөрвүүлэх сонголтыг зөвхөн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрсөн бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарим хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эхний ээлжинд худалдан авах давуу эрхээ эдлэхээс татгалзсан тохиолдолд хийж болно. Энэ тохиолдолд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК үлдэгдэл хувьцаануудыг өмнөх хувьцаа эзэмшигчдэд санал болгосонтой ижил үнээр КэйЭфДаблю-д санал болгох үүрэгтэй. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн капиталын хэмжээг өсгөх зориулалтаар шинээр гаргах хувьцааны үнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтооно. Энэ нөхцөл байдалд КэйЭфДаблю хувьцаанд хөрвүүлэх сонголтоо хэрэгжүүлэхдээ хувьцааг бэлэн мөнгөөр худалдан авах эсвэл КэйЭфДаблю хоёрдогч өглөгийн үлдэгдлийг эргүүлэн төлөх хүсэлтийг Банкинд гаргаж эргүүлэн авсан эх үүсвэрээ ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа худалдан авахад зарцуулж болно. Аль ч сонголтын хувьд КэйЭфДаблю ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцааг худалдан авахад төлөх төлбөр ижил дүнтэй байна.

Хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн үед КэйЭфДаблю-гийн шинээр эзэмших хувьцаа нь бүрэн саналын эрхтэй энгийн хувьцаа байх бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн бусад бүх хувьцаатай тэнцүү эрхтэй байна. Уг хувьцааны нийт хэмжээ нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн нийт хувьцаат капиталын 20%-иас илүү байж болохгүй.

Банк нь банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө алдах, төлбөрийн чадвараа алдах, татан буугдах, бүтцийн зохион байгуулалтад орох болон Монголбанкнаас зөвшөөрөл авснаас бусад бүх тохиолдолд зээлийг хугацаа дуусахаас нь өмнө эргэн төлж болохгүй. Банк татан буугдах тохиолдолд тус өглөг нь бусад бүх зээлдүүлэгчдийн өр төлөгдсөний дараагаар төлөгдөнө.

28. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Инкофин Импульс Бичил Санхүүгийн Хөрөнгө Оруулалтын Сангаас авсан хоёрдогч өглөг

Энэхүү хоёрдогч өглөгийн зээлийг нэг удаагийн төлөлтөөр бэлэн мөнгө хэлбэрээр 2016 оны 12-р сард буюу зээл авснаас 84 сарын дараа төлнө. Зээлийн жилийн хүү 9.25% (2013 онд 9.25%) байна.

29. ХОЙШЛОГДСОН НӨХЦӨЛТ ХАНДИВ

	2014 мян.төг	2013 мян.төг
Микро Энержи Кредит Корпораци (“МЭК”)	895,938	954,444
ЭКО сан	451,985	657,433
Цэвэр агаар сан	169,194	280,543
Жижиг Бизнес Боловсрол олгож Дэмжих Сүлжээ (“ЖББДС”)	67,684	59,374
Олон Улсын Санхүүгийн Корпораци (“ОУСК”)	31,479	-
Дэлхийн Эмэгтэйчүүдийн Банк (“ДЭБ”)	3,247	2,848
Ядууст Туслах Зөвлөх Нэгж (“ЯТЗН”)	3,004	2,635
	1,622,531	1,957,277

Хойшлогдсон нөхцөлт хандивын хөдөлгөөнийг дор үзүүлэв:

	2014 мян.төг	2013 мян.төг
Тайлант жилийн эхний үлдэгдэл	1,957,277	1,576,638
Тайлант жилд хүлээн авсан	569,132	1,704,573
Дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн	(903,878)	(1,323,934)
Тайлант жилийн эцсийн үлдэгдэл	1,622,531	1,957,277

30. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2014 мян.төг	2013 мян.төг
Өглөг	15,126,101	10,732,051
Клирингийн саатал	6,080,769	2,409,462
Ногдол ашгийн өглөг (Тодруулга 33)	39	1,243
	21,206,909	13,142,756

31. ЭНГИЙН ХУВЬЦАА

	Нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцааны тоо		Дүн	
	2014	2013	2014 мян.төг	2013 мян.төг
1-р сарын 1-ний өдрөөр/ 12-р сарын 31-ний өдрөөр	<u>20,353,656</u>	<u>20,353,656</u>	<u>20,353,656</u>	<u>20,353,656</u>

32. БУСАД НӨӨЦ

Тайлант жилийн туршид бусад нөөцөд хөдөлгөөн гараагүй бөгөөд тайлант өдрийн байдлаар, энэхүү нөөц сангийн зориулалтын талаар ТУЗ-өөс баримталж буй тодорхой бодлого байхгүй байна.

33. НОГДОЛ АШИГ

	2014 мян.төг	2013 мян.төг
1-р сарын 1-ний өдрөөр, ногдол ашгийн өглөг	1,243	1,243
Тайлант жилд зарласан ногдол ашиг	-	-
Тайлант жилд төлсөн ногдол ашиг	<u>(1,204)</u>	<u>-</u>
12-р сарын 31-ний өдрөөр, ногдол ашгийн өглөг (Тодруулга 30)	<u>39</u>	<u>1,243</u>

34. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

		2014 мян.төг	2013 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	13	187,780,433	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	14	138,422,940	121,851,611
Монголбанкны үнэт цаас	17	79,862,222	224,745,335
Засгийн газрын үнэт цаас	17	<u>116,442,440</u>	<u>89,661,748</u>
		<u>522,508,035</u>	<u>674,873,564</u>
Хасах нь: Банкны өдөр тутмын үйл ажиллагааг үл санхүүжүүлэх, Монголбанкинд заавал байлгах нөөц (Тодруулга 13)		(110,568,265)	(89,484,500)
Хасах нь: Бусад банкинд байршуулсан, анхны дуусвар хугацаа нь гурван сараас дээш харилцах, хадгаламж		(76,379,494)	-
Хасах нь: Монголбанкны анхны дуусвар хугацаа нь гурван сараас дээш үнэт цаас		-	-
Хасах нь: Засгийн газрын анхны дуусвар хугацаа нь гурван сараас дээш үнэт цаас		<u>(42,732,781)</u>	<u>(65,417,281)</u>
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		<u>292,827,495</u>	<u>519,971,783</u>

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Бодит үнэ цэнийг тодорхойлох ба бодит үнэ цэнийн зэрэглэл

Банк нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах шатлалуудыг хэрэглэдэг. Үүнд:

Зэрэглэл 1: Бодит үнэ цэнэ нь ижил төстэй актив, пассивын идэвхтэй зах зээл дээр тогтоосон үнэд үндэслэсэн байх;

Зэрэглэл 2: Бодит үнэ цэнийг хэмжихдээ хэрэглэсэн мэдээ нь зах зээл дээрээс шууд ба шууд бусаар олдох боломжтой бусад техникүүд; ба

Зэрэглэл 3: Зах зээлийн мэдээлэлд үндэслэгдээгүй мэдээ ашиглан бодит үнэ цэнийг тооцоолох арга ашиглан тооцоолсон техникүүд.

Дараах хүснэгтэнд бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнийн зэрэглэлээр нь ангилан үзүүлэв:

	Зэрэглэл 1 мян.төг	Зэрэглэл 2 мян.төг	Зэрэглэл 3 мян.төг	Нийт мян.төг
2014.12.31-ний өдрөөр				
Санхүүгийн хөрөнгө				
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд				
Валютын своп хэлцэл	-	1,469,087	-	1,469,087
Валютын форвард хэлцэл	-	-	-	-
	-	1,469,087	-	1,469,087
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө				
Тогтмол орлоготой хөрөнгө	-			
оруулалтууд		6,929,591	-	6,929,591
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй	-			
өмчийн үнэт цаас		-	821,800	821,800
	-	6,929,591	821,800	7,751,391
Санхүүгийн өр төлбөр				
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд				
Валютын своп хэлцэл	-	2,427,739	-	2,427,739
2013.12.31-ний өдрөөр				
Санхүүгийн хөрөнгө				
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд				
Валютын своп хэлцэл	-	40,002	-	40,002
Валютын форвард хэлцэл	-	596,833	-	596,833
	-	636,835	-	636,835
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө				
Тогтмол орлоготой хөрөнгө	-			
оруулалтууд		14,725,194	-	14,725,194
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй	-			
өмчийн үнэт цаас		-	775,500	775,500
	-	14,725,194	775,500	15,500,694
Санхүүгийн өр төлбөр				
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд				
Валютын форвард хэлцэл	-	626,804	-	626,804

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнийг тодорхойлох ба бодит үнэ цэнийн зэрэглэл (үргэлжлэл)

Бодит үнэ цэнээрээ хэмжигддэггүй ч бодит үнэ цэнэ нь бодит үнэ цэнийн хүснэгтэнд толилуулагддаг санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Ашиглах боломжтой зах зээлийн өгөгдлүүдийг ашиглан үнэлгээний аргачлал (дискаунтлагдсан мөнгөн урсгалын загвар) дээр суурилан Банкны тооцсон эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь 2 дугаар түвшинд ангилагддаг.

1 болон 2 дугаар түвшний хоорондох хөдөлгөөн

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн, санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийн 1 болон 2 дугаар түвшний хооронд ямар нэг хөдөлгөөн гараагүй.

Гол таамаглалуудын өөрчлөлтийн бодит үнэ цэнээр хэмжигдсэн 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийн нөлөө

Бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй тул 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолох таамаглалын боломжит өөрчлөлтийн нөлөөг өртгөөр нь бүртгэсэн.

Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ хараахан бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглах аргачлал, таамаглалыг доор харуулав.

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо хөрөнгө

Дуусвар хугацаа нь богино (нэг хүртэл жил) болон түргэн борлогдох санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн дансны үнийг бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо гэж үзнэ. Уг таамаглалыг хугацаагүй болон хугацаатай хадгаламж, янз бүрийн хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүдэд мөн ашиглана. Удирдлагын гүйцэтгэсэн бодит үнэ цэнийн үнэлгээнд үндэслэн бодит үнэ цэнийг нь тооцсон нэгээс дээш жилийн хугацаатай бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн бодит үнэ цэнэ нь санхүүгийн байдлын тайлан дахь дансны үнэтэй ойролцоо байна. Энэ нь голчлон ижил төрлийн хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийн өнөөгийн зах зээлийн хүүний түвшин нь анхны зах зээлийн хүүний түвшнээс хол зөрүүгүй байгаатай холбоотой.

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнийг тодорхойлох ба бодит үнэ цэнийн зэрэглэл (үргэлжлэл)

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг Монгол улс дах ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн зах зээлийн хүү болон тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүтэй харьцуулан тооцно.

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй Банкны санхүүгийн хэрэгслүүдийг ангилал бүрээр нь дансны болон бодит үнэ цэнээр нь харьцуулан дараах хүснэгтээр харууллаа. Энэхүү хүснэгтэд санхүүгийн бус хөрөнгө болон санхүүгийн бус өр төлбөрийн бодит үнэ цэнийг оруулаагүй болно.

2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр	Тодруулга	Дансны үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	13	187,780,433	187,780,433
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	14	138,422,940	138,422,940
Урвуу репо хэлцэл	15	152,799,124	152,799,124
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	1,469,087	1,469,087
Санхүүгийн хөрөнгө оруулалт			
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй		-	-
- борлуулахад бэлэн	17	7,751,391	7,751,391
- дуусвар хугацаа хүртэл эзэмших	17	211,594,397	211,594,397
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	1,313,697,656	1,327,022,796
Бусад хөрөнгө	19	1,162,016	1,162,016
		2,014,677,044	2,028,002,184
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	24	34,317,691	34,317,691
Репо хэлцэл	25	179,763,676	179,763,676
Харилцагчдын харилцах, хадгаламж	26	797,749,013	797,749,013
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	2,427,739	2,427,739
Зээлээр авсан санхүүжилт	27	803,560,458	806,506,445
Хоёрдогч өглөг	28	97,925,342	100,665,549
Бусад өр төлбөр	30	13,352,137	13,352,137
		1,929,096,056	1,934,782,250

35. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2013 оны 12-р сарын 31-ний өдрөөр	Тодруулга	Дансны үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	13	238,614,870	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	14	121,851,611	121,851,611
Урвуу репо хэлцэл	15	29,991,255	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	636,835	636,835
Санхүүгийн хөрөнгө оруулалт			
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй		-	-
- борлуулахад бэлэн	17	15,500,694	15,500,694
- дуусвар хугацаа хүртэл эзэмших	17	329,582,816	329,582,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	1,029,541,294	1,042,319,028
Бусад хөрөнгө	19	814,841	814,841
		1,766,534,216	1,779,311,950
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	24	141,706,978	141,706,978
Репо хэлцэл	25	162,428,300	162,428,300
Харилцагчдын харилцах, хадгаламж	26	644,483,183	644,483,183
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	626,804	626,804
Зээлээр авсан санхүүжилт	27	664,368,204	663,319,039
Хоёрдогч өглөг	28	58,637,886	54,742,966
Бусад өр төлбөр	30	13,008,046	13,008,046
		1,685,259,401	1,680,315,316

36. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд, Банк янз бүрийн цуцалж үл болох санхүүгийн хэлцлүүдэд оролцдог. Хэдийгээр, эдгээр үүрэг хариуцлагууд нь санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй байж болох ч, эдгээр нь зээлийн эрсдэл агуулдаг бөгөөд үүгээрээ Банкны хүлээж буй эрсдлийн нэг хэсэг юм.

	2014 мян.төг	2013 мян.төг
Болзошгүй өр төлбөр		
Гүйцэтгэлийн болон тендерийн баталгаа	17,745,358	14,709,938
Санхүүгийн баталгаа	12,677,708	10,938,113
Аккредитив	19,907,191	3,815,847
	50,330,257	29,463,898
Үүрэг		
Олгогдоогүй зээл	25,752,212	33,229,645
Нийт	76,082,469	62,693,543

Болзошгүй өр төлбөр

Аккредитив, баталгаа (нээлттэй аккредитив хамаарагдана) нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотойгоор төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нээлттэй аккредитив нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг. Эдгээр гүйлгээний улмаас материаллаг алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

Олгогдоогүй зээл

Зээлийн хэмжээг нэмэхээр шийдвэрлэсэн нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Зээлийн хэмжээг нэмэх шийдвэрүүд нь харилцагчийн тодорхой шалгууруудыг хангах явдлаас шууд шалтгаалдаг учраас зээлийн боломжит алдагдал нь нийт хэрэгжээгүй үлдсэн зээл олгох үүргүүдийн дүнгээс бага байна. Богино хугацаат зээлийн үүргээс голдуу урт хугацаат зээлийн үүрэг нь илүүтэйгээр зээлийн эрсдэлтэй байдаг тул банк нь зээлийн үүргүүдийнхээ дуусах хугацааг хянаж байдаг.

Бусад үүрэг хариуцлагууд

	2014 мян.төг	2013 мян.төг
Батлагдаж, гэрээ байгуулсан:		
Үндсэн хөрөнгө	1,061,475	338,156
Биет бус хөрөнгө	52,668	44,467
Сургалт	15,000	-
Зар сурталчилгаа	8,745	25,020
Хангамжийн материал	4,253	-
	1,142,141	407,643

36. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үйл ажиллагааны түрээсийн үүрэг – Банк түрээслэгчээр

Банк нь цуцлах боломжтой, үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээслэгч болж төрөл бүрийн барилгыг үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслэдэг. Банк эдгээр гэрээнүүдийн хугацааг дуусгавар болгох тохиолдолд мэдэгдлээ нэг сарын өмнө өгөх үүрэгтэй. Түрээсийн гэрээнд аливаа шинэчлэх, худалдан авах, сайжруулах боломжуудыг тусгаагүй ба Банк эдгээр түрээсийн гэрээний тал болсноор аливаа хязгаарлалтууд тавигдаагүй болно.

Үйл ажиллагааны түрээсийн үүрэг – Банк түрээслүүлэгчээр

Банк нь цуцлах боломжтой, үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээслүүлэгч болж төрөл бүрийн барилгыг үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслүүлдэг. Банк эдгээр гэрээнүүдийн хугацааг дуусгавар болгох тохиолдолд мэдэгдлээ нэг сарын өмнө өгөх үүрэгтэй. Түрээсийн гэрээнд аливаа шинэчлэх, худалдан авах, сайжруулах боломжуудыг тусгаагүй ба Банк эдгээр түрээсийн гэрээний тал болсноор аливаа хязгаарлалтууд тавигдаагүй болно.

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандаа залруулах бичилт хийнэ. Тайлант жилийн эцэст Банкинд шийдэгдээгүй шүүхийн нэхэмжлэл байхгүй байсан.

Татварын хууль тогтоомж

Монгол Улсын татвар, валют болон гаалийн талаарх хууль тогтоомж нь өөр өөр ойлголтуудыг төрүүлэхээр бөгөөд түүний хажуугаар байнга өөрчлөгдөж байдаг. Банкны ажил гүйлгээнүүдэд нөлөөлсөн эдгээр хууль тогтоомжийн талаарх удирдлагын ойлголт нь татварын байгууллагуудаар шалгагдаж болох юм.

Монгол улсын татварын байгууллагууд нь үүнд өөрсдийн тайлбар болон үнэлгээндээ илүү бат байр суурь баримталж болох ба урьд өмнө нь хэлэлцэж байгаагүй үйл ажиллагаа болон ажил гүйлгээг татварын байгууллага энд үгүйсгэж болно. Үүний үр дүнд мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулж болох талтай. Татварын байгууллага нь шалгаж буй тайлант жилээс өмнөх 5 хүртэлх жилийн хугацааны татварын асуудлыг сөхөж шалгах эрхтэй байдаг. Зарим тодорхой нөхцөл байдалд үүнээс ч өмнөх хугацааг хамран шалгах боломжтой юм.

36. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Татварын хууль тогтоомж (үргэлжлэл)

Монгол Улсын шилжүүлгийн үнэ тогтоох тухай хууль тогтоомжууд нь дотоод, гадаадын шилжүүлгийн үнэ тогтоохтой холбоотой бүхий л хянах боломжтой ажил гүйлгээнүүдэд шилжүүлгийн үнийн залруулга хийж нэмэлт татвар ногдуулах боломжийг татварын байгууллагуудад олгодог. Гүйлгээний нөхцөл нь зах зээлийн нөхцлөөс өөр тохиолдолд татварын байгууллага нь татвар ногдуулах дүнгүүдийг залруулж нэмэлт татвар, торгууль болон алданги тооцох эрхтэй. Монгол Улсын шилжүүлгийн үнэ тогтоохтой холбоотой өнөөгийн дүрэм журмын товч, хураангуй байдлаас шалтгаалан уг асуудлын нөлөөг баттайгаар тооцоолох боломжгүй. Энэ нь байгууллагын санхүүгийн байдал буюу нийт үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байх магадлалтай юм.

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын, ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татвар, суутгагчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар болон бусад татварын хуулиудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Ийм зарим нэг тохиолдолд удирдлага нь эдгээр тайлбарлалт нь тодорхой бус байх боломжтой хууль тогтоомжуудыг Банкинд ногдох татварын хувь хэмжээг бууруулах байдлаар тайлбарлан үнэлдэг. Дээр дурьдсаны дагуу сүүлийн үед бий болсон захиргааны болон шүүхийн практикын шинэчлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь улам хатуу хяналт шалгалтанд өртөж болно. Хэдийгээр Банкны санхүүгийн байдал хийгээд нийт үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэх боломжтой боловч татварын байгууллагын байр суурийг урьдчилан баттайгаар таамаглах боломжгүй болно. Энэ нь байгууллагын санхүүгийн байдал буюу нийт үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байх магадлалтай юм.

Удирдлага татварын хууль тогтоомжоос үүсэх эрсдлүүдээ тогтмол эргэн хянаж байдаг ба өнөө үед баттайгаар урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлын улмаас ирээдүйд Банкны байр суурь өөрчлөгдөж болно.

37. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ДУУСВАР БОЛОХ ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Дараах хүснэгтэнд Банкны хөрөнгө ба өр төлбөрийн эргэн төлөгдөх, эсвэл барагдах хугацаагаар нь ангилсан шинжилгээг харуулсан. Тодруулга 39.3 "Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага"-аас Банкны зүгээс барагдуулах гэрээт үүргүүдийн бууруулж тооцоогүй хувилбарыг харна уу.

37. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ДУУСВАР БОЛОХ ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр	12 сар хүртэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах	187,780,433	-	187,780,433
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	138,422,940	-	138,422,940
Урвуу репо хэлцэл	152,799,124	-	152,799,124
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	129,752	1,339,335	1,469,087
Санхүүгийн хэрэглүүр:			
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй	-	-	-
- борлуулахад бэлэн	161,491	7,589,900	7,751,391
- дуусвар хугацаа хүртэл эзэмших	206,343,519	5,250,878	211,594,397
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	555,838,730	757,858,926	1,313,697,656
Бусад хөрөнгө	549,512	612,504	1,162,016
	1,242,025,501	772,651,543	2,014,677,044
Санхүүгийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	-	31,241,651	31,241,651
Биет бус хөрөнгө	195,244	8,212,431	8,407,675
Бусад хөрөнгө	5,346,957	93,128	5,440,085
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	10,727,557	-	10,727,557
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	2,321,415	2,321,415
	16,269,758	41,868,625	58,138,383
Нийт	1,258,295,259	814,520,168	2,072,815,427
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	34,317,691	-	34,317,691
Репо хэлцэл	179,763,676	-	179,763,676
Харилцагчдын харилцах, хадгаламж	623,008,720	174,740,293	797,749,013
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	1,724,251	703,488	2,427,739
Зээлээр авсан санхүүжилт	314,738,003	488,822,455	803,560,458
Хоёрдогч өглөг	-	97,925,342	97,925,342
Бусад өр төлбөр	13,018,322	333,815	13,352,137
	1,166,570,663	762,525,393	1,929,096,056

ХАСБАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ДУУСВАР БОЛОХ ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	12 сар хүртэлх	12 сараас дээш	Нийт
2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр	мян.төг	мян.төг	мян.төг
Санхүүгийн бус өр төлбөр			
Хойшлогдсон нөхцөлт хандив	1,622,531	-	1,622,531
Бусад өр төлбөр	3,986,656	3,868,116	7,854,772
Орлогын татварын өр	401,316	-	401,316
	6,010,503	3,868,116	9,878,619
Нийт	1,172,581,166	766,393,509	1,938,974,675
Цэвэр позиц	85,714,093	48,126,659	133,840,752
	12 сар хүртэлх	12 сараас дээш	Нийт
2013 оны 12-р сарын 31-ний өдрөөр	мян.төг	мян.төг	мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	238,614,870	-	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	121,851,611	-	121,851,611
Урвуу репо хэлцэл	29,991,255	-	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	636,835	-	636,835
Санхүүгийн хэрэглүүр:			
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй	-	-	-
- борлуулахад бэлэн	13,250,686	2,250,008	15,500,694
- дуусвар хугацаа хүртэл эзэмших	314,407,083	15,175,733	329,582,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	432,757,504	596,783,790	1,029,541,294
Бусад хөрөнгө	642,863	171,978	814,841
	1,152,152,707	614,381,509	1,766,534,216
Санхүүгийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	-	29,595,235	29,595,235
Биет бус хөрөнгө	1,334,192	4,332,224	5,666,416
Бусад хөрөнгө	3,453,853	93,128	3,546,981
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	5,105,763	-	5,105,763
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	1,035,981	1,035,981
	9,893,808	35,056,568	44,950,376
Нийт	1,162,046,515	649,438,077	1,811,484,592

37. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ДУУСВАР БОЛОХ ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	12 сар хүртгэлх мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	126,820,078	14,886,900	141,706,978
Репо хэлцэл	162,428,300	-	162,428,300
Харилцагчдын харилцах, хадгаламж	514,686,171	129,797,012	644,483,183
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	626,804	-	626,804
Зээлээр авсан санхүүжилт	319,390,992	344,977,212	664,368,204
Хоёрдогч өглөг	-	58,637,886	58,637,886
Бусад өр төлбөр	9,461,435	3,546,611	13,008,046
	1,133,413,780	551,845,621	1,685,259,401
Санхүүгийн бус өр төлбөр			
Хойшлогдсон нөхцөлт хандив	1,957,277	-	1,957,277
Бусад өр төлбөр	134,710	-	134,710
Орлогын татварын өр	1,928,160	-	1,928,160
	4,020,147	-	4,020,147
Нийт	1,137,433,927	551,845,621	1,689,279,548
Цэвэр позиц	24,612,588	97,592,456	122,205,044

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь Банкыг эзэмшдэг. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг Тодруулга 1-ээс харна уу.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад зээл олгох, хадгаламж байршуулах, гадаад валютын гуйвуулгын гүйлгээ хийх зэрэг хэд хэдэн гүйлгээг холбоотой талуудтай хийсэн. Эдгээр ажил гүйлгээг арилжааны нөхцлөөр зах зээлийн ханшаар гүйцэтгэсэн.

12-р сарын 31-ний өдрийн байдлаар, Банкны хувьд холбоотой талуудтай хийсэн гүйлгээ болон тухайн өдрөөрх дансны үлдэгдэл нь дараах байдалтай байна. Үүнд:

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2014 мян.төг	2013 мян.төг
а) Холбоотой компаниудад олгосон зээл болон урьдчилгаа		
Толгой компани	8,778,839	7,764,896
Толгой компанийн бусад охин компаниуд	1,523,177	-
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	-	2,482,228
	<u>10,302,016</u>	<u>10,247,124</u>
Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүд болон гол удирдах албан тушаалтнууд	2,116,556	1,349,988
	<u>12,418,572</u>	<u>11,597,112</u>

Холбоотой талуудад олгосон барьцаат зээл болон урьдчилгаа нь жилийн 6.5%-иас 27.6% (2013 онд 6.5%-27.6%)-ийн хүүтэй ба 1-14 хүртэл жилийн эргэн төлөгдөх хугацаатай байна. Тайлант жилд эдгээр зээлээс олсон хүүгийн орлого нь 2,894.3 сая төгрөг (2013 онд 541.1 сая төгрөг) болно.

	2014 мян.төг	2013 мян.төг
б) Холбоотой компаниудын харилцах, хадгаламж:		
Толгой компани	330,566	899,935
Толгой компанийн бусад охин компаниуд	13,948,882	3,920,519
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	1,623,768	1,006,434
	<u>15,903,216</u>	<u>5,826,888</u>
Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Гишүүд болон гол удирдах албан тушаалтнууд	1,486,837	541,406
	<u>17,390,053</u>	<u>6,368,294</u>

Холбоотой талуудын байршуулсан харилцах, хадгаламж нь жилийн 0%-иас 15% (2013 онд 0%-иас 14.6%)-ийн хүүтэй байсан. Дээрх харилцах болон хадгаламж эзэмшигчдэд тайлант жилд 481.6 сая төгрөг (2013 онд 324.9 сая төгрөг)-ийн хүүгийн зардал төлсөн.

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2014 мян.төг	2013 мян.төг
в) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдээс авсан зээл:		
Европийн Сэргээн Босголт Хөгжлийн Банк	69,649,344	49,916,201
Триодос Фэйр Шэйр Сан	-	1,710,939
	69,649,344	51,627,140

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдээс авсан зээл нь жилийн 6.59%-иас 12.24% (2013 онд 6.59%-иас 16.73%)-ийн хүүтэй байсан. Тайлант жилд эдгээр зээлд төлсөн хүүгийн зардал нь 4,293.5 сая төгрөг (2013 онд 3,096.7 сая төгрөг) байсан.

	2014 мян.төг	2013 мян.төг
г) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдээс авсан хоёрдогч өглөг:		
Олон Улсын Санхүүгийн Корпораци	84,842,434	22,328,823

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн дээрх хувьцаа эзэмшигчдээс авсан хоёрдогч өглөг нь жилийн 6.5%+6 сарын Лайбор болон 8.955% хүүтэй (2013 онд 6.5%+6 сарын Лайбор болон 8.95%) байсан. Тайлант жилд хоёрдогч өглөгт төлсөн хүүгийн зардал нь 4,516.99 сая төгрөг (2013 онд 1,583.4 сая төгрөг) байсан.

	2014 мян.төг	2013 мян.төг
д) Төлсөн харуул хамгаалалтын зардал:		
Толгой компанийн бусад охин компани	2,008,645	1,861,551

38. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2014 мян.төг	2013 мян.төг
е) Холбоотой компаниудаас авсан шимтгэлийн орлого:		
Толгой компани	1,060	2,678
Толгой компанийн бусад охин компани	5,003	3,719
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	7,838	39,761
	13,901	46,158
Банкны ТУЗ-ийн гишүүд ба гол удирдах албан тушаалтнууд	5,098	4,205
	18,999	50,363
ё) Холбоотой компанид төлсөн гэрээний төлбөр:		
Толгой компани	3,435,550	2,954,600
Толгой компанийн бусад охин компани	266,030	297,109
	3,701,580	3,251,709
ж) Холбоотой компаниудаас авсан түрээсийн орлого:		
Толгой компанийн бусад охин компани	78,048	24,844
	78,048	24,844
л) Гол удирдах албан тушаалтнуудад олгосон нөхөн олговор:		
Ажилчдад олгосон богино хугацаат тэтгэмж:		
Цалин	3,566,637	1,663,138
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	387,982	182,329
	3,954,619	1,845,467

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний нөхцлүүд

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурьдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Холбоотой талуудын төлсөн болон хүлээн авсан хүү нь ердийн арилжааны хүүгээр тооцогдсон. Тайлант жилийн эцсээрхи үлдэгдэл дүн барьцаагаар хангагдаагүй болно. Бусад холбоотой талуудын өглөг эсвэл авлагын дүнд ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй. 2014 болон 2013 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант жилүүдэд Банк өөрийн холбоотой талуудтай холбоотойгоор эргэлзээтэй авлагын сан байгуулаагүй болно.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

39.1 Оршил

Эрсдэл нь банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг ба эдгээр эрсдлийг байнгын илрүүлэлт, хэмжилт, хяналтын үйл явцуудаар дамжуулан удирддаг. Банк нь зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл, урьдчилан төлөлтийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдлүүдтэй учирч байдаг. Эдгээр эрсдлүүд нь Банкны ашигт ажиллагаа болон хөрөнгөнд шууд алдагдал учруулах, эсхүл банкны бизнесийн зорилгуудын биелэлтэд саад учруулж болзошгүй байдаг.

Банк нь эрсдлийг бүрмөсөн арилгахад чиглэхээс илүүтэйгээр эрсдэл, өгөөжийг хамгийн оновчтой хослуулахад чиглэсэн эрсдлийн удирдлагын бодлоготой. Одоо мөрдөж буй эрсдлийн удирдлагын систем нь дараах зарчмуудыг агуулсан байна. Үүнд:

- (i) Эрсдлүүдийг удирдаж буй этгээд нь зохицуулалтын болон хэмжилтийн системийг сайн ойлгож байх;
- (ii) Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан бодлогын дагуу эрсдлийг хэмжиж байх; ("ТУЗ");
- (iii) ТУЗ-өөс баталсан бодлогын дагуу эрсдлийг хэмжиж байх;
- (iv) Капиталын хуваарилалт нь эрсдлийн түвшинтэйгээ уялдаж байх;
- (v) Банкны гүйцэтгэлийн хэмжилт нь эрсдэл даах байдалтай уялдаж байх.

Эрсдлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

ТУЗ нь эрсдлийг бүхэлд нь удирдах бөгөөд эрсдлийн бодлого, зарчмуудыг батлах үүрэгтэй. Гэсэн хэдий ч, эрсдлийг удирдах, хянах чиг үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдлийн удирдлагын хороо ("ТЭУХ") ба Эрсдлийн удирдлагын хороо ("ЭУХ")

ЭУХ нь дээд түвшний эрсдлийн удирдлагын бодлого, зохицуулалтыг боловсруулдаг. ЭУХ нь бизнесийн газар, нэгжүүдийн санхүүгийн эрсдлүүдийг урьдчилан илрүүлж, удирдах мөн хүлээх эрсдлийн зохистой хэмжээг тогтоож өгөх, санхүүгийн эрсдэл ба гүйцэтгэлийг хэмжих зохистой систем, стандартууд бий болгох, эрсдлийн тайлагнал ба удирдлагын хяналтын цогц үйл явцуудыг нэвтрүүлэх үүрэгтэй. ТЭУХ нь ЭУХ-ны боловсруулсан бизнесийн стратегиудыг хянах, батлах үүрэгтэй.

Эрсдлийн Нэгдсэн Удирдлагын Газар

Банкны Эрсдлийн нэгдсэн удирдлагын газар нь өдөр тутмын санхүүгийн байдал хийгээд зах зээлийн эрсдлийг тодорхойлох, хэмжих, хянах, удирдах шууд хариуцлагыг хүлээнэ. Энэ газар нь мөн Банкны зээлийн багцын эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл болон үйл ажиллагааны эрсдлийг хариуцах үндсэн үүрэгтэй.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.1 Оршил (Үргэлжлэл)

Дотоод аудит

Банкны эрсдлийн удирдлагын үйл явцад Дотоод аудитын газар жилд нэг удаа аудит хийх ба аудитын үед банкны журмуудын зохистой байдал хийгээд Банк эдгээр журмуудыг хэр мөрдөж байгаад хяналт хийдэг. Дотоод аудитын газар нь хийсэн бүх үнэлгээнийхээ үр дүнг банкны удирдлагатай хэлэлцэж, илрүүлсэн алдаа, дутагдал болоод өгөх зөвлөмжүүдийн талаар Аудитын хороонд тайлагнана.

Эрсдлийг хэмжих болон тайлагнах систем

Банк нь статистик загваруудын тусламжтайгаар түүхэн алдагдлаас тооцсон ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй онцгой алдагдлыг давхар хэмжиж чадах системийг ашиглан эрсдлийг хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг. Тохиолдохгүй байх өндөр магадлалтай байсан туйлын ховор үйл явдал үнэхээр тохиолдсон үед гарч болох хамгийн муу үр дагавруудыг бас авч үздэг.

Эрсдлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьж байдаг.

Эрсдлийг цаг алдалгүй олж таних, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилж үздэг. Ингэж боловсруулсан мэдээллийг ТУЗ, ТЭУХ, ЭУХ, бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлбарладаг. Тайланд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцын хэмжээ, кредит метрикийн таамаглал, тогтоосон лимитийн гажилт, VaR, хөрвөх чадварын харьцаа болон эрсдлийн утгуудын өөрчлөлтийг тусгана. Сар бүр үйлдвэрлэлийн салбар, харилцагчийн эрсдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлагнана. Улирал бүр газар нэгжийн захирлууд ЗТУБАХ сангийн зохистой байдалд үнэлгээ өгнө. Хяналтын зөвлөл Банкны нийт эрсдэлд өртөж болзошгүй багцыг тооцож, үнэлж, хянаж болохуйц бүрэн хэмжээний тайлантай улирал бүр танилцаж, үнэлгээ хийдэг.

Тусгайлан боловсруулсан эрсдлийн тайланг Банкны бүх нэгжүүдэд хүргэдэг бөгөөд энэ нь бизнесийн нэгжүүдийг хамгийн сүүлийн үеийн шинэ мэдээлэлтэй байлгах зорилготой юм.

Гүйцэтгэх зөвлөл ба банкны холбогдох бусад бүх гишүүдэд VaR, хөрвөх чадварын шинжилгээ, зах зээлийн эрсдлийн лимитийн биелэлт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулна.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.1 Оршил (Үргэлжлэл)

Эрсдлийг бууруулах

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээ болон VaR аргаар тооцон, хянаж ажилладаг. Банк зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө авдаг.

Эрсдлийн хэт төвлөрөл

Төвлөрөл нь ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн ойролцоо шинж чанартай бизнес эрхэлдэг хэд хэдэн харилцагчид улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал үүсдэг. Төвлөрөл нь тухайн нэг салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Зээлийн эрсдэлд тодорхойлогдсон төвлөрлийг хянаж удирдана. Монголбанк /Төв банк/ дараах стандарт хязгаарлалтуудыг тогтоож, биелүүлэхийг шаарддаг. Үүнд :

- (i) Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад активын нийлбэр дүн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй.
- (ii) Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад активын дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтрэхгүй.

39.2 Зээлийн эрсдэл

Банкны харилцагч, үйлчлүүлэгч, зээлдэгч, зээлийн хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болох эсхүл төлөхийг хүсэхгүй байх, зээлийн гэрээний болон бусад санхүүгийн хэрэгслүүдтэй холбоотой үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлд Банк өртдөг.

Банкны Эрсдлийн удирдлагын хороо нь ("ЭУХ") дахь Зээлийн удирдлагын газраар ("ЗУГ") дамжуулан Банкны зээлийн багцыг хэт төвлөрүүлэхгүй байхаар удирдан ажилладаг. ЗУГ нь банкны хүлээх зээлийн эрсдлийн түвшинг нэг зээлдэгч болон нэг бүлэг зээлдэгч эсхүл нэг аж үйлдвэрийн салбарын хувьд хүлээн зөвшөөрч болох эрсдлийн хэмжээнд хязгаар тавих замаар зохицуулдаг. Ийм эрсдлүүдийг эргэж хянаж байдаг бөгөөд хязгаарыг жилд нэгээс доошгүй удаа дахин хянадаг. Нэг харилцагчид олгох зээлийн дээд хэмжээ болон зээлийн бүтээгдэхүүний багцын хязгаар зэргийг ТУЗ батлах ба ЭУХ-оос тодорхой хугацаа тутамд хяналт хийнэ.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Зээлийн төлбөрийг эргүүлэн төлөх чадвартай зээлдэгч болон зээлдэгчийн зээлжих чадвар болон зээлдэгч нь хүү болон капиталын эргэн төлөлтийн үүргээ биелүүлэх явдлыг шинжлэх байдлаар, мөн шаардлагатай бол дээр дурьдсан хязгааруудыг шинэчлэн өөрчлөх замаар зээлийн эрсдлийг удирдана. Зээлийн эрсдлийг барьцаа хөрөнгө, компанийн болон гуравдагч этгээдийн батлан даалтаар мөн бууруулж болно.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаануудыг гаргах боломжийг бий болгодог. Ийм төлбөрийг аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчдаас эргүүлэн татдаг. Эдгээр нь банкинд зээлтэй нэгэн адил эрсдлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого журмаар зохицуулдаг.

Эдгээр хэрэглүүрүүдийн үндсэн зорилго нь шаардлагатай үед харилцагчийн төлбөрийг хийхэд эх үүсвэр хангалттай байгаа эсэхийг баталгаажуулах явдал юм. Баталгаа ба харилцагч гуравдагч талын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон үед Банк харилцагчийн өмнөөс төлбөрийг хийнэ гэсэн буцаах боломжгүй баталгааг илэрхийлдэг нээлттэй аккредитив нь зээлтэй адил эрсдэлтэй байна.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдлийн дээд хэмжээг авч үзвэл:

Доорх хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцыг харуулсан байна. Эрсдэлд өртөж болох нийт багцыг барьцаа хөрөнгөөр эрсдлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

	Тодруулга	Нийт багцын хэмжээ 2014 мян.төг	Нийт багцын хэмжээ 2013 мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь үлдэгдэл (касс дахь бэлэн мөнгийг оролцуулаагүй)	13	145,990,603	202,049,732
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	14	138,422,940	121,851,611
Урвуу репо хэлцэл	15	152,799,124	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	1,469,087	636,835
Санхүүгийн хөрөнгө оруулалт – борлуулахад бэлэн	17	7,751,391	15,500,694
Санхүүгийн хөрөнгө оруулалт – дуусвар хугацаа хүртэл эзэмших	17	211,594,397	329,582,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	18	1,361,818,904	1,048,010,209
Бусад хөрөнгө	19	1,162,016	821,338
Нийт		2,021,008,462	1,748,444,490
Болзошгүй өр төлбөр	36	50,330,257	29,463,898
Санхүүгийн үүрэг хариуцлагууд	36	25,752,212	33,229,645
Нийт		76,082,469	62,693,543
Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн		2,097,090,931	1,811,138,033

Бодит үнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэгслийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдлийн өртөлтийг харуулсан ба энэ нь ирээдүйд үнэ цэнэ өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдлийн дээд хэмжээ биш юм.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)****Эрсдлийн төвлөрөл (аж үйлдвэрийн салбараар)**

Доорх хүснэгтэнд Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг (Тодруулга 18) аж үйлдвэрийн салбар болоод эдийн засгийн зорилгоор нь ангилан, нийт дүнгээр (зээлийн барьцаа хөрөнгө эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийн бодит үнийг авч үзэхээс өмнөх болон дараах дүнгээр) нь үзүүлэв.

	2014		2013	
	Нийт багцын хэмжээ		Нийт багцын хэмжээ	
	мян.төг	%	мян.төг	%
Худалдаа	312,112,759	22.92	239,755,254	22.88
Орон сууц	220,233,804	16.17	160,660,934	15.33
Үйлдвэрлэл	215,311,310	15.81	157,643,667	15.04
Үйлчилгээ	174,132,449	12.79	133,135,580	12.70
Хэрэглээний зээл	134,270,861	9.86	117,358,126	11.20
Барилга	99,753,180	7.33	74,682,028	7.13
Бусад	69,651,066	5.11	40,807,730	3.89
Хадгаламж барьцаалсан	82,380,202	6.05	40,745,118	3.89
Уул уурхай	17,134,711	1.26	31,725,348	3.03
Ажиллагсдын зээл	12,989,060	0.95	25,869,567	2.47
Хөдөө аж ахуй	21,831,129	1.60	24,276,869	2.32
Удирдах гол ажиллагсдын зээл	2,018,373	0.15	1,349,988	0.12
Нийт	1,361,818,904	100	1,048,010,209	100

Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд

Шаардлагатай барьцаа хөрөнгийн дүн болон төрөл нь зээлдэгч болон харилцагчийн зээлийн эрсдлийн үнэлгээ ба олгох зээлийн төрлөөс хамаарна. Банк нь барьцаанд авах хөрөнгийн төрөл болон үнэ цэнийг тодорхойлохдоо Зээлийн удирдлагын хорооноос гаргасан зааварчилгааг дагаж мөрддөг.

Барьцаанд авсан хөрөнгүүдийн гол төрлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- (i) Жижиг бизнесийн, хэрэглээний, хөдөө аж ахуйн, жижиг дунд үйлдвэрлэлийн, ажиллагсдын зээлүүдийн хувьд бэлэн мөнгө, баталгаа, үнэт цаас, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, бараа материал гэх мэт;
- (ii) Орон сууц худалдан авах зээлийн хувьд орон сууц ба тээврийн хэрэгсэл;
- (iii) Бөөний зээлийн хувьд бэлэн мөнгө, хувьцаа, үл хөдлөх хөрөнгө;
- (iv) Хадгаламж барьцаалсан зээлүүдийн хувьд мөнгөн хадгаламж.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)****Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд (Үргэлжлэл)**

Банк нь барьцаа хөрөнгүүдийг биетээр нь шалгаж үздэг ба тэдгээрийн зах зээлийн үнийг тогтмол хянаж байдаг. Шаардлагатай бол гэрээнд заасны дагуу нэмэлт барьцаа хөрөнгийг авдаг. Зээлийн алдагдлаар хаах сангийн хэмжээ зохистой байгаа эсэхийг шалгах үедээ барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг хянаж үздэг.

Санхүүгийн хөрөнгийн бүлэг нэг бүрийн чанар

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны чанарыг Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний системийг ашиглан удирддаг.

Банкны зээлийн эрсдлийн үнэлгээний системийг дараах хүснэгтээр үзүүлэв:

<u>Зээлийн зэрэглэл</u>	<u>Тодорхойлолт</u>
A	Маш сайн
B	Сайн
C	Хангалттай
D	Хэвийн бус

Банк тус 4 зэрэглэлтэй эрсдлийн үнэлгээг системийг нийт зээлийн багцыг эрсдлийн шинж чанарын дагуу бүлэглэхийн тулд ашигладаг. Эрсдлийн үнэлгээний системээр зээлийг зэрэглэхдээ параметрик байдлаар загварчилж байна. Энэ арга нь зээлийн эрсдлийн зэрэглэлийг тодорхойлохдоо зээлийн эрсдэх магадлалыг тоогоор илэрхийлж гаргадаг. Тоон болон чанарын түүхэн өгөгдлүүд нь Банкны зээлийн эрсдлийн удирдлагын хэлтэст хэрэглэж буй төсөөллүүдийн үндэс суурь болж өгдөг. Эрсдлийн зэрэглэлийн системийг тодорхой нэг зээлийн эрсдэлд байгуулах сангийн хэмжээг тооцоход ашиглана. Одоо хэрэглэж буй эрсдлийн зэрэглэлийн систем нь дөрвөн зэрэглэлтэй.

Банк зээлийн багцдаа зохистой, байнгын эрсдлийн зэрэглэл тогтоож байх бодлогыг баримтладаг. Энэ нь зарим төрлийн эрсдлийг удирдах боломжийг олгохын зэрэгцээ, бүх зээлүүдийн эрсдлийг нэг хэмжигдэхүүнээр илэрхийлэн харуулах боломжийг олгодог. Үнэлгээний систем нь харилцагчийн зээлийн эрсдэлд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн статистик шинжилгээ болон зах зээлийн мэдээлэлд суурьлагдан хийгддэг. Эрсдлийн зэрэглэл нь төрөл бүрийн зээлийн эрсдэлтэй уялдсан бөгөөд зээл эрсдэх тохиолдолд алдагдлыг бууруулах барьцаа хөрөнгө, эсхүл бусад төрлийн алдагдлыг бууруулах хэрэгслүүдийг тухайн зээл тус бүр ялгаатай байна гэсэн бодлогыг баримталдаг.

Банк нь хөрөнгийн биржид бүртгэлгүй санхүүгийн хөрөнгө оруулалтад үнэлгээ тогтоодоггүй. Доорх хүснэгтэд зээлийн чанарыг Банкны зээлийн дотоод үнэлгээний систем дээр үндэслэн зээлтэй холбоотой хөрөнгийг бүлэг тус бүрээр нь үзүүлэв. Үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй дүнгээр үзүүлэв.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

	Тодруулга	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хөрөнгө					Хугацаа хэтэрсэн эсвэл тусдаа үнэ цэнийн бууралттай	Нийт
		Маш сайн	Сайн	Хангалттай	Хэвийн бус	Үнэлээгүй		
2014 оны 12-р сарын 31-ний байдлаар		мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь үлдэгдэл	13	187,780,433	-	-	-	-	-	187,780,433
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	14	110,918,938	2,029,332	1,927,720	23,546,950	-	-	138,422,940
Урвуу репо хэлцэл	15	152,799,124	-	-	-	-	-	152,799,124
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	1,469,087	-	-	-	-	-	1,469,087
Санхүүгийн хөрөнгө оруулалтууд								
-борлуулахад бэлэн	17	-	-	-	-	7,751,391	-	7,751,391
-дуусвар хугацаа хүртэл эзэмших	17	211,594,397	-	-	-	-	-	211,594,397
Зээл ба урьдчилгаа								
ЖДБ-ийн зээл	18	16,990,405	113,616,653	401,467,249	33,896,868	75,096	107,978,986	674,025,257
Орон сууцны зээл	18	61,982,978	17,856,882	137,350,651	7,028,207	157,082	4,436,314	228,812,114
Бичил бизнесийн зээл	18	18,310,589	13,285,082	175,080,989	4,509,840	-	8,591,402	219,777,902
Хэрэглээний зээл	18	18,679,467	35,183,410	47,063,672	2,740,412	-	5,834,149	109,501,110
Санхүүгийн түрээс	18	12,470,913	6,627,880	9,907,590	255,338	-	2,123,771	31,385,492
Бусад	18	95,139,451	508,913	1,237,649	-	-	1,431,016	98,317,029
		223,573,803	187,078,820	772,107,800	48,430,665	232,178	130,395,638	1,361,818,904
Бусад хөрөнгө	19	1,162,016	-	-	-	-	139,084	1,301,100
Нийт		889,297,798	189,108,152	774,035,520	71,977,615	7,983,569	130,534,722	2,062,937,376

ХАСБАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

	Тодруулга	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн санхүүгийн хөрөнгө					Хугацаа хэтэрсэн эсвэл тусдаа үнэ цэнийн бууралттай	Нийт
		Маш сайн мян.төг	Сайн мян.төг	Хангалттай мян.төг	Хэвийн бус мян.төг	Үнэлээгүй мян.төг	мян.төг	
2013 оны 12-р сарын 31-ний байдлаар								
Бэлэн мөнгө ба Монголбанкн дахь үлдэгдэл	13	238,614,870	-	-	-	-	-	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	14	35,697,104	1,754,191	-	84,400,316	-	-	121,851,611
Урвуу репо хэлцэл	15	29,991,255	-	-	-	-	-	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	16	636,835	-	-	-	-	-	636,835
Санхүүгийн хөрөнгө оруулалтууд								
-борлуулахад бэлэн	17	-	-	-	-	15,500,694	-	15,500,694
-дуусвар хугацаа хүртэл эзэмших	17	329,582,816	-	-	-	-	-	329,582,816
Зээл ба урьдчилгаа								
ЖДБ-ийн зээл	18	107,827,265	105,308,640	289,050,367	20,715,050	525,026	23,682,527	547,108,875
Орон сууцны зээл	18	51,720,506	19,216,992	102,324,465	6,689,342	260,792	931,771	181,143,868
Бичил бизнесийн зээл	18	15,724,929	6,403,293	126,253,493	2,462,821	-	1,608,011	152,452,547
Хэрэглээний зээл	18	20,815,519	35,245,535	41,994,269	2,302,918	-	1,675,412	102,033,653
Санхүүгийн түрээс	18	10,474,830	5,612,390	6,618,053	275,857	-	304,466	23,285,596
Бусад	18	40,793,156	19,464	1,057,944	22,096	-	93,010	41,985,670
		247,356,205	171,806,314	567,298,591	32,468,084	785,818	28,295,197	1,048,010,209
Бусад хөрөнгө	19	814,841	-	-	-	-	49,484	864,325
Нийт		882,693,926	173,560,505	567,298,591	116,868,400	16,286,512	28,344,681	1,785,052,614

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Харилцагчдад олгосон хугацаа хэтэрсэн зээл болон урьдчилгаанд зөвхөн цөөн хэдэн хоногоор хугацаа хэтэрсэн зээлүүд орсон. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн насжилтын шинжилгээг дор үзүүлэв. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн дийлэнх нь үнэ цэнийн бууралтанд ороогүй гэж үзсэн.

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтанд ороогүй санхүүгийн хөрөнгүүдийн насжилтын шинжилгээ

	30 хоног хүртэл мян.төг	31-60 хоног мян.төг	61-90 хоног мян.төг	91-ээс дээш хоног мян.төг	Нийт мян.төг
2014.12.31-нээр					
Зээл ба урьдчилгаа					
ЖДБ-ийн зээл	61,825,441	1,177,273	3,794,413	17,533,012	84,330,139
Орон сууцны зээл	1,220,744	667,862	344,137	2,203,571	4,436,314
Бичил бизнесийн зээл	2,582,592	1,387,427	996,050	3,625,333	8,591,402
Хэрэглээний зээл	1,754,091	1,039,217	560,820	2,480,021	5,834,149
Санхүүгийн түрээс	844,293	319,362	207,582	752,534	2,123,771
Бусад	982,413	75,916	31,044	341,643	1,431,016
	69,209,574	4,667,057	5,934,046	26,936,114	106,746,791

	30 хоног хүртэл мян.төг	31-60 хоног мян.төг	61-90 хоног мян.төг	91-ээс дээш хоног мян.төг	Нийт мян.төг
2013.12.31-нээр					
Зээл ба урьдчилгаа					
ЖДБ-ийн зээл	1,795,138	2,670,233	973,836	1,152,543	6,591,750
Орон сууцны зээл	311,179	17,449	8,709	594,434	931,771
Бичил бизнесийн зээл	495,747	161,871	185,594	764,799	1,608,011
Хэрэглээний зээл	320,764	404,213	106,893	843,542	1,675,412
Санхүүгийн түрээс	70,488	18,365	6,568	190,695	286,116
Бусад	5,672	40,263	4,768	42,307	93,010
	2,998,988	3,312,394	1,286,368	3,588,320	11,186,070

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)**

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтанд ороогүй санхүүгийн хөрөнгүүдийн насжилтын шинжилгээ (Үргэлжлэл)

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтанд ороогүй зээл, урьдчилгааны нийт дүнд Банк нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 154,997 сая төгрөг (2013 онд 21,552 сая төгрөг)-ийн үнэ бүхий барьцаа хөрөнгийг авсан байна. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанд байгуулсан үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 18-аас харна уу.

Дахин бүтэцчилсэн санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг тус бүрийн дансны үнэ

Дахин бүтэцчилсэн санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнийг бүлэг тус бүрээр нь доорх хүснэгтэд үзүүлэв.

	2014 мян. төг	2013 мян. төг
Зээл ба урьдчилгаа:		
ЖДБ-ийн зээл	2,241,423	106,532
Орон сууцны зээл	3,325	-
Бичил бизнесийн зээл	52,174	72,479
Хэрэглээний зээл	41,949	35,974
Санхүүгийн түрээс	-	-
Бусад	-	15,435
	2,338,871	230,420

Үнэ цэнийн бууралтын шинжилгээ

Зээлийн үндсэн ба хүүгийн графикт төлбөр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн, зээлдэгчийн мөнгөн урсгалд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлийн үнэлгээ буурсан, зээлийн гэрээний анхны нөхцлүүд зөрчигдсөн эсэх зэрэг асуудлуудыг зээлийн үнэ цэнийн бууралтын шинжилгээ хийх явцад авч үздэг. Банк нь үнэ цэнийн бууралтын шинжилгээг бүлгийн ба тусгайлсан үнэлгээ гэж ялган авч үздэг.

Тусгайлсан үнэлгээгээр үнэлсэн үнэ цэнийн бууралтын хасагдуулга

Банк нь өндөр дүнтэй зээл ба урьдчилгаанд нэг бүрчлэн зээлийн эрсдлийн тохирох санг тооцдог. Зээлийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тортвортой байдал, санхүүгийн хүндрэл тохиолдсон үед гүйцэтгэлээ сайжруулах чадвар, дампуурал тохиолдсон үед хүлээн авах төлбөрүүд болон хүлээгдэж буй ногдол ашгийн төлбөрүүд, санхүүгийн өөр бусад дэмжлэг авах боломжууд, барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хугацаа зэргийг зайлшгүй авч үздэг. Үнэ цэнийн бууралтаас үүсэх алдагдлын хэмжээг, гэнэтийн үйл явдлуудын улмаас илүү нухацтай авч үзэх шаардлагатай байгаагаас бусад тохиолдолд тайлант өдөр бүр үнэлж үзнэ.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Бүлгийн үнэлгээгээр үнэлсэн эрсдлийн сан

Чухал ач холбогдолгүй бүх зээл ба урьдчилгаа ба чухал ач холбогдолтой боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо гарч ирээгүй зээл ба урьдчилгаануудыг бүлэглэн, бүлэг тус бүр дээр хүлээж болзошгүй алдагдлыг тооцно. Удирдлагын зүгээс бүлгийн үнэлгээг улирал бүр бүлэг тус бүрт ялгаатай шинжилгээнд үндэслэн хийнэ.

Бүлгийн үнэлгээнд тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй боловч тэдгээрийг багтаасан багцын түвшинд оршин байх магадлалтай үнэ цэнийн бууралтыг тооцдог. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүлгийн алдагдлын түүхэн өгөгдөл, эдийн засгийн өнөөгийн байдал, алдагдал гарсан гэж таамаглаж буй үе болон уг алдагдлыг олж тогтоосон үе хоорондын ойролцоолсон хугацаа мөн үнэ цэнийн бууралттай гэж тогтоогдсоны дараа хүлээгдэж буй эргэн төлөгдөх эсвэл цуглуулан авах дүн зэрэг мэдээлэл дээр үндэслэн тогтоодог.

Бүлгийн үнэлгээ нь нэг жилийн давтамжтайгаар хийгдэх ба Банкны удирдлага энэхүү давтамжийг өөрчлөх эсэхийг шийднэ. Зээлийн удирдлагын газар зээлийн үнэ цэнэ бууралтын сан нь Банкны нийт бодлоготой нийцэж байгаа эсэхт хяналт тавьж байна.

39.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон тогтворгүй нөхцөл байдалд харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэж чадахгүй байвал банк төлбөрийн чадварын эрсдэлд орно. Харилцагчдын гэнэтийн их хэмжээний бэлэн мөнгөний татан авалтын үед бэлэн байх ёстой эх үүсвэрийн доод хэмжээг Банк тогтоож өгдөг. Зээлээр авсан болон өөрийн эх үүсвэрийн зохистой харьцааг барьж байх бодлогыг Банк баримталдаг. Үүнээс гадна Банк нь нийт харилцагчдын хадгаламжийн 12%-тай (2013: 12%) тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкинд заавал байршуулж байх ёстой.

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

Доорх хүснэгтэд 2014 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөрүүдийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүргүүд дээр үндэслэн харууллаа. Урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр төлөгдөх ёстой өр төлбөрийн хувьд уг мэдэгдэл тэр даруй ирсэн гэж тооцов. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүд дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.3 Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөр	Хугацаагүй мян.төг	3 сараас доош мян.төг	3-6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Санхүүгийн өр төлбөрийн дискаунтлаагүй нийт дүн мян.төг
2014 оны 12-р сарын 31							
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	147,978	17,610,477	365,924	17,657,586	-	-	35,781,965
Репо хэлцэл	181,567,843	-	-	-	-	-	181,567,843
Харилцагчдын харилцах, хадгаламж	293,334,544	89,962,275	143,598,262	120,300,871	92,452,985	193,028,169	932,677,106
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	389,399	1,289,541	45,311	-	703,488	-	2,427,739
Зээлээр авсан санхүүжилт	5,432,679	12,703,868	176,840,061	158,464,747	510,774,994	27,767,372	891,983,721
Хоёрдогч өглөг	622,178	1,244,355	1,866,533	3,733,065	49,442,392	81,438,289	138,346,812
Бусад өр төлбөр	6,479,471	5,488,538	33,378	1,016,935	327,232	6,583	13,352,137
Нийт	487,974,092	128,299,054	322,749,469	301,173,204	653,701,091	302,240,413	2,196,137,323

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.3 Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөр	Хугацаагүй мян.төг	3 сараас доош мян.төг	3-6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Санхүүгийн өр төлбөрийн дискаунтлаагүй нийт дүн мян.төг
2013 оны 12-р сарын 31							
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	42,591,420	11,529,916	71,689,665	5,634,272	16,170,895	-	147,616,168
Репо хэлцэл	163,376,128	-	-	-	-	-	163,376,128
Харилцагчдын харилцах, хадгаламж	281,748,808	81,126,184	91,892,028	76,880,988	73,311,241	134,039,344	738,998,593
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	507,866	46,626	72,312	-	-	-	626,804
Зээлээр авсан санхүүжилт	7,702,394	91,029,693	98,155,226	152,556,959	340,307,803	39,198,750	728,950,825
Хоёрдогч өглөг	390,745	781,489	1,172,234	2,344,467	57,548,551	16,755,173	78,992,659
Бусад өр төлбөр	2,477,788	96,999	1,570	6,885,078	336,802	3,209,809	13,008,046
Нийт	498,795,149	184,610,907	262,983,035	244,301,764	487,675,292	193,203,076	1,871,569,223

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.3 Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ (Үргэлжлэл)

Доорхи хүснэгтэнд болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлагуудыг гэрээгээр дуусах хугацаагаар нь ангилж харуулав.

	Хугацаагүй мян.төг	3 сараас доош мян.төг	3-6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Санхүүгийн өр төлбөрийн дискаунтлаагүй нийт дүн мян.төг
2014 оны 12-р сарын 31							
Болзошгүй өр төлбөр (Тодруулга 36)	21,703,548	7,929,009	8,042,436	7,604,166	1,279,898	3,771,200	50,330,257
Санхүүгийн үүрэг хариуцлагууд (Тодруулга 36)	543,339	847,715	7,016,117	5,288,939	12,056,102	-	25,752,212
Нийт	22,246,887	8,776,724	15,058,553	12,893,105	13,336,000	3,771,200	76,082,469
2013 оны 12-р сарын 31							
Болзошгүй өр төлбөр (Тодруулга 36)	2,286,623	10,807,157	3,831,072	11,211,766	1,327,280	-	29,463,898
Санхүүгийн үүрэг хариуцлагууд (Тодруулга 36)	224,422	1,235,885	5,161,011	1,566,399	25,041,928	-	33,229,645
Нийт	2,511,045	12,043,042	8,992,083	12,778,165	26,369,208	-	62,693,543

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**39.4 Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш гэх мэт зах зээлийн хувьсагчуудын өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдлийг хэлнэ. Банк нь эрсдлийн энэ элементийг VaR болон мэдрэмжийн шинжилгээг ашиглан хянаж удирддаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд ноцтой, зах зээлийн эрсдлийн төвлөрөл байхгүй байна.

Хүүгийн түвшний эрсдэл

Тодорхой хугацааны заагуудад хүүгийн түвшинг тохируулж өгч байх шаардлагатай позицууд хоорондоо таарамжгүй болох үед хүүгийн эрсдэл бий болдог. Банкны зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүгийн эрсдлийг бий болгодог. Хүүгийн хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүгийн цэвэр орлогод тэр даруй нөлөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөд нөлөөлдөг (Банкны хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуурх зүйлсийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлөх учраас). Тодорхой хугацаанд байж болох хүүгийн хувь хэмжээний өөрчлөлтийн хязгаарыг Банкны удирдлага тогтоож өгдөг. Позицуудыг өдөр бүр хянаж байдаг ба хейджинг стратеги хэрэгжүүлэх замаар позицийг хязгаарын хүрээнд удирдаж ажилладаг. Дараах хүснэгтэнд Банкны орлогын тайлангийн зүйлүүдийн, бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүгийн хувь хэмжээний зохистой, боломжит өөрчлөлтүүдэд үзүүлэх мэдрэмжийг харуулав. Орлогын тайлангийн мэдрэмж гэж нэг жилийн хүүгийн цэвэр орлогод хүүгийн өөрчлөлт (2014 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн хөвөгч хүүгийн өөрчлөлт)-ийн үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Валют	Өсөлт/ (Бууралт)	Цэвэр хүүгийн орлогын мэдрэмж мян.төг
2014 оны 12-р сарын 31		
Америк доллар	+120	(2,372,242)
Төгрөг	+120	742,393
Америк доллар	-120	2,372,242
Төгрөг	-120	(742,393)
2013 оны 12-р сарын 31		
Америк доллар	+120	(1,050,786)
Төгрөг	+120	(260,176)
Америк доллар	-120	1,050,786
Төгрөг	-120	260,176

Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ гадаад валютын ханшийн сөрөг өөрчлөлтийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм. Банкны удирдлага гадаад валютын позицууд дээр хязгаар тогтоож өгдөг ба тэдгээрийг тогтмол хянадаг. Үүнээс гадна Банк нь гадаад валютын эрсдлийг удирдах, хэмжих үйл ажиллагаандаа VaR загварыг 2007 оны 3 дугаар сараас хэрэглэж эхэлсэн. VaR нь тодорхой хугацаанд ба өгөгдсөн итгэлцлийн түвшинд багцын зах зээлийн үнэд гарч болох өөрчлөлтийг ойролцоолон тооцоолох замаар санхүүгийн эрсдлийг хэмжихэд ашиглагддаг арга юм.

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**39.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)****VaR аргачлалын зорилго, төсөөлөл, хязгаарлалтууд**

VaR загвар нь зах зээлийн хэвийн орчинд зах зээлийн эрсдлийг хэмжихэд ашигладаг. Эдгээр загварууд нь зах зээлийн хэвийн орчинд нөлөө үзүүлж буй эрсдлийн хүчин зүйлүүд дээр гарч буй аливаа өөрчлөлтүүд нь хэвийн тархалттай байна гэж авч үздэг. Банк нь өнгөрсөн нэг өдрийн түүхэн өгөгдөлд суурилан валютын багцад гарч болох өөрчлөлтүүдийг тооцоолохдоо вариаци/ковариацийн загварыг ашигладаг. Банкны хэрэглэж буй VaR аргачлал нь 99 хувийн итгэлцлийн түвшин ба хэрэв одоогийн зах зээлийн эрсдлийн хэмжээ нэг өдөр өөрчлөгдөхгүй хэвээр байхад болзошгүй алдагдлын хэмжээ нь хэтэрч илүү гарахгүй байх 1 өдрийн хугацааг ашигладаг ба эдгээр хувьсагчуудыг зах зээлийн өгөгдлийн 250 өдрийн хөдөлгөөнийг ажигласны үндсэн дээр тодорхойлдог. 99%-ийн итгэлцлийн түвшинг ашиглана гэдэг нь VaR-ын дүнгээс илүү гарсан алдагдалтай өдөр 100 өдөр тутамд нэгээс илүү тохиолдохгүй гэсэн үг.

VaR нь зах зээлийн үнэ ба үнийн ирээдүйн хөдөлгөөн нь статистик тархалттай байна гэж үздэг, мөн зах зээлийн үнийн түүхэн корреляц ба огцом өөрчлөлтүүд дээр суурилдаг учраас энэ аргыг хэрэглэхэд зарим нэг хязгаарлалтууд байдаг. VaR арга нь мэдээллийг гаргахдаа түүхэн өгөгдлүүд дээр их тулгуурладаг, эрсдлийн хүчин зүйлүүдийн ирээдүйн өөрчлөлт ба хөдөлгөөнийг тодорхой харуулж чаддаггүй зэргийн улмаас хэрэв эрсдлийн хүчин зүйлүүдийн өөрчлөлт нь хэвийн тархалттай байна гэсэн төсөөллөөс зөрвөл, зах зээлийн том хөдөлгөөний магадлалыг дутуу үнэлж болно. Эрсдлийн хүчин зүйлүүд ба тодорхой нэг хэрэглүүрүүдийн хувьд тэдгээр хүчин зүйлүүдийн хоорондын хамаарлын талаар хийсэн төсөөллүүдийн улмаас VaR нь дутуу эсвэл илүү тооцоолж болно. Позицууд нь өдрийн туршид өөрчлөгдөөгүй байсан ч VaR нь зөвхөн ажлын өдөр дуусах үеийн байдлаарх багцын эрсдлийг илэрхийлдэг ба 99 хувийн итгэлцлийн түвшнээс давсан аливаа нэг алдагдлыг тооцож үздэггүй.

VaR нь 2007 оны 3 дугаар сараас Банкны зах зээлийн эрсдлийн удирдлагын салшгүй нэг хэсэг болсон. VaR-ын хязгаар ба алдагдлын хэмжээ нь удирдлагаас тогтоож өгсөн хязгаарт байгаа эсэхийг тогтмол шалгаж үздэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүр дээр нэг өдрийн хугацаанд гарч болох алдагдлын хэмжээг VAR аргаар тооцоолж гаргасныг дор үзүүлэв. Үүнд:

	Варианц/ Коварианц мян.төг		Варианц/ Коварианц мян.төг
2014.12.31-ний өдөр	142,365	2013.12.31-ний өдөр	182,098
2014 оны өдрийн дундаж	81,007	2013 оны өдрийн дундаж	163,584
2014 оны дээд хэмжээ	559,746	2013 оны дээд хэмжээ	736,814
2014 оны доод хэмжээ	12,781	2013 оны доод хэмжээ	13,728

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2014.12.31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэнд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв:

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн төвлөрөл	Төгрөг мян.төг	Ам.доллар мян.төг	Евро мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2014 оны 12-р сарын 31					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь үлдэгдэл	95,845,673	70,164,987	1,062,207	20,707,566	187,780,433
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	35,732	126,105,367	7,097,504	5,184,337	138,422,940
Урвуу репо хэлцэл	152,799,124	-	-	-	152,799,124
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	1,469,087	-	-	-	1,469,087
Санхүүгийн хөрөнгө оруулалт					
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй	-	-	-	-	-
- борлуулахад бэлэн	7,374,271	377,120	-	-	7,751,391
- дуусвар хугацаа хүртэл эзэмших	211,594,397	-	-	-	211,594,397
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,058,742,983	253,013,431	52,399	1,888,843	1,313,697,656
Бусад хөрөнгө	665,786	480,273	12,200	3,757	1,162,016
	<u>1,528,527,053</u>	<u>450,141,178</u>	<u>8,224,310</u>	<u>27,784,503</u>	<u>2,014,677,044</u>
Өр төлбөр					
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	25,305	16,925,859	-	17,366,527	34,317,691
Репо хэлцэл	179,763,676	-	-	-	179,763,676
Харилцагчдын харилцах, хадгаламж	635,141,674	144,110,631	6,984,021	11,512,687	797,749,013
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	2,427,739	-	-	-	2,427,739
Зээлээр авсан санхүүжилт	286,055,393	516,175,466	1,329,599	-	803,560,458
Хоёрдогч өглөг	-	97,925,342	-	-	97,925,342
Бусад өр төлбөр	8,202,938	4,148,909	11,907	988,383	13,352,137
	<u>1,111,616,725</u>	<u>779,286,207</u>	<u>8,325,527</u>	<u>29,867,597</u>	<u>1,929,096,056</u>
Цэвэр хөрөнгө/(өр төлбөр)	<u>416,910,328</u>	<u>(329,145,029)</u>	<u>(101,217)</u>	<u>(2,083,094)</u>	<u>85,580,988</u>

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2013.12.31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв:

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн төвлөрөл	Төгрөг мян.төг	Ам.доллар мян.төг	Евро мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2013 оны 12-р сарын 31					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь үлдэгдэл	205,488,160	27,629,100	1,678,407	3,819,203	238,614,870
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	35,346	119,217,395	787,942	1,810,928	121,851,611
Урвуу репо хэлцэл	29,991,255	-	-	-	29,991,255
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	636,835	-	-	-	636,835
Санхүүгийн хөрөнгө оруулалт					
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй	-	-	-	-	-
- борлуулахад бэлэн	15,169,874	330,820	-	-	15,500,694
- дуусвар хугацаа хүртэл эзэмших	329,582,816	-	-	-	329,582,816
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	644,842,284	382,214,988	2,483,473	549	1,029,541,294
Бусад хөрөнгө	381,266	433,575	-	-	814,841
	<u>1,226,127,836</u>	<u>529,825,878</u>	<u>4,949,822</u>	<u>5,630,680</u>	<u>1,766,534,216</u>
Өр төлбөр					
Бусад банк ба санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламж	122,041,803	19,665,175	-	-	141,706,978
Репо хэлцэл	162,428,300	-	-	-	162,428,300
Харилцагчдын харилцах, хадгаламж	555,345,295	80,043,835	3,731,877	5,362,176	644,483,183
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	626,804	-	-	-	626,804
Зээлээр авсан санхүүжилт	286,527,991	376,668,159	1,172,054	-	664,368,204
Хоёрдогч өглөг	-	58,637,886	-	-	58,637,886
Бусад өр төлбөр	10,841,503	484,124	48,771	1,633,648	13,008,046
	<u>1,137,811,696</u>	<u>535,499,179</u>	<u>4,952,702</u>	<u>6,995,824</u>	<u>1,685,259,401</u>
Цэвэр хөрөнгө/(өр төлбөр)	88,316,140	(5,673,301)	(2,880)	(1,365,144)	81,274,815

39. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

39.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Урьдчилан төлөлтийн эрсдэл

Урьдчилан төлөлтийн эрсдэл гэдэг нь Банкны үйлчлүүлэгч ба харилцагч нь хүлээж байснаас өмнө эсвэл хойно төлбөрөө хийх эсвэл төлбөр хийхийг хүссэний улмаас Банк санхүүгийн алдагдалд орох эрсдэл юм.

Банк нь төрөл бүрийн түвшний урьдчилан төлөлтүүдийн хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолохдоо хялбаршуулсан аргыг авч хэрэглэдэг.

Хэрэв бусад бүх хувьсагчдыг тогтмол гэж үзэн эргэн төлөгдөх санхүүгийн хэрэгсэлийн 20% нь жилийн эхэнд урьдчилан төлөгдсөн бол жилийн эцсийн татварын өмнөх ашиг 41,495 (2013: 31,469) сая төгрөгөөр буурахаар байсан байна.

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хувь хүний санамсаргүй болон санаатай үйлдэл болон бусад гадаад хүчин зүйлүүдийн улмаас Банк алдагдалд орж болох эрсдэл юм. Хяналт ажиллахгүй байх үед үйл ажиллагааны эрсдэл нь нэр хүнд унах, хуулийн болон зохицуулалтын асуудалд орох, улмаар санхүүгийн алдагдалд ороход ч хүргэж болно. Банк хэдийгээр үйл ажиллагааны эрсдлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдлийг удирдаж болно. Хяналтад ажил үүргийн хуваарь, хяналттай системд нэвтрэх, батлах, тулган баталгаажуулах журмууд, боловсон хүчний боловсрол, үнэлгээний үйл явцууд багтана. Мөн дотоод аудиторын ажлыг ашиглах явдал орно.

40. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Банк бизнесийн салшгүй эрсдлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

Өнгөрсөн жилийн турш Банк нь өөрийн хөрөнгөнд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

40. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (ҮРГЭЛЖЛЭЛ)**Капиталын удирдлага**

Банкны капиталын удирлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба бизнесээ дэмжиж хувь нийлүүлэгчдийн үнэлэмжийг ихэсгэхийн тулд зээлийн эрсдлийн түвшин болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Банк капиталынхаа бүтцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэгсэл гаргах, эсвэл өөрийн хөрөнгөд уялдсан үнэт цаас гаргах зэрэг арга замуудыг ашигладаг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2013 онд 9%), өөрийн хөрөнгө эрсдлээр жинлэсэн активын харьцааг 14% (2013 онд 14%)-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдлийн уг шинж чанараар нь тохируулсан актив болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дараах байдлаар үзүүлэв:

	2014	2013
Өөрийн хөрөнгийн харьцаа	9.81%	11.18%
Эрсдлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн харьцаа	16.99%	16.54%
	2014	2013
	мян.төг	мян.төг
<u>I зэрэглэлийн хөрөнгө</u>		
Энгийн хувьцаа	20,353,656	20,353,656
Нэмэгдэж төлөгдсөн капитал	34,989,097	34,989,097
Бусад сан	10,531,368	10,531,368
Хуримтлагдсан ашиг	67,966,631	56,330,923
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	<u>133,840,752</u>	<u>122,205,044</u>
<u>II зэрэглэлийн хөрөнгө</u>		
Хоёрдогч өглөг	<u>97,925,342</u>	<u>58,637,886</u>
Нийт капитал/капиталын суурь	<u>231,766,094</u>	<u>180,842,930</u>

40. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (ҮРГЭЛЖЛЭЛ)**Зохицуулалттай капитал (Үргэлжлэл)**

12-р сарын 31-ний байдлаар эрсдлээр нь жинлэсэн активуудыг эрсдлийн ангилал тус бүрээр нь үзүүлбэл:

	2014		2013	
	Актив	Эрсдлээр жинлэсэн	Актив	Эрсдлээр жинлэсэн
%	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
0	569,426,359	-	600,068,943	-
20	58,289,591	11,657,918	41,085,010	8,217,002
50	195,860,088	97,930,044	168,975,171	84,487,585
70	341,551,765	239,086,235	270,835,197	189,584,638
100	976,754,003	976,754,003	781,893,170	781,893,170
150	4,443,211	6,664,816	2,549,261	3,823,891
<i>Тохируулга:</i>				
Үйл ажиллагааны эрсдлийн харьцаа		23,635,505		15,946,833
Гадаад валютын эрсдлийн харьцаа		8,038,924		9,251,000
Нийт	2,146,325,017	1,363,767,445	1,865,406,752	1,093,204,119

41. АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувилбарийг баримтална.

42. ТАЙЛАГНАЛЫН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Тайлагналын өдрөөс хойш санхүүгийн тайланд тодруулах шаардлагатай томоохон үйл явдал тохиолдоогүй болно.